



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2025 оны II улирлын санхүүгийн тайлан

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР

Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй Дүүрэг, Бага тойруу 3, Засгийн газрын
IV байр. Утас: 51-261668 Цахим шуудан: nbfi@frc.mn

Агуулга

Хүснэгтийн жагсаалт.....	3
Зургийн жагсаалт.....	4
Товчилсон нэрсийн жагсаалт.....	4
Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал.....	5
Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт, хэрэгжилт.....	7
Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт.....	8
Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилт.....	8
Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт.....	8
“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт.....	8
Статистик үзүүлэлтүүд.....	9
Харилцагчид, зээлдэгчид.....	9
Хувьцаа эзэмшигчид болон ажилчид.....	9
Тархалт.....	10
Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт.....	11
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө.....	12
Хөрөнгө оруулалт.....	13
Зээл.....	13
Цахим зээл	16
Ногоон зээл	18
Факторингийн тооцооны авлага.....	19
Үүсмэл санхүүгийн хөрөнгө, бусад санхүүгийн хөрөнгө.....	20
Санхүүгийн бус хөрөнгө.....	20
Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт.....	21
Итгэлцлийн үйлчилгээний өглөг.....	22
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр.....	23
Бусад эх үүсвэр.....	23
ББСБ-аас гаргасан өрийн бичиг.....	24
Төслийн зээлийн санхүүжилт.....	24
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ХБҮЦ).....	25
Бусад санхүүгийн өр төлбөр.....	25
Санхүүгийн бус өр төлбөр.....	26
Өөрийн хөрөнгө.....	26
Хувь нийлүүлсэн хөрөнгө.....	26
Өөрийн хөрөнгийн бусад хэсэг.....	27
Хуримтлагдсан ашиг.....	28
Ашигт ажиллагаа.....	29
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд.....	30
Дүгнэлт.....	31
Актив, пассивын бүтэц.....	32
Ашигт ажиллагаа.....	32
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.....	33

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 ББСБ-уудын тоо мэдээлэл.....	5
Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан ерөнхий үзүүлэлтүүд (тэрбум төгрөгөөр).....	5
Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа.....	5
Хүснэгт 4 Харилцагч, зээлдэгчдийн мэдээлэл.....	9
Хүснэгт 5 Статистик мэдээлэл (5 жилээр).....	9
Хүснэгт 6 ББСБ-ын мэдээлэл.....	10
Хүснэгт 7 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа.....	10
Хүснэгт 8 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт.....	10
Хүснэгт 9 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт.....	10
Хүснэгт 10 Активын үзүүлэлтүүд (сая төгрөгөөр).....	11
Хүснэгт 11 Активын интервал (тэрбум төгрөгөөр).....	12
Хүснэгт 12 Мөнгөн хөрөнгийн бүтэц (тэрбум төгрөгөөр).....	12
Хүснэгт 13 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц (сая төгрөгөөр).....	13
Хүснэгт 14 Зээлийн бүтэц (тэрбум төгрөгөөр).....	13
Хүснэгт 15 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар (сая төгрөгөөр).....	15
Хүснэгт 16 Зээлийн ангилал (тэрбум төгрөгөөр).....	16
Хүснэгт 17 Зээлийн ангилал (мянган төгрөгөөр).....	16
Хүснэгт 18 Цахим зээл олгож байгаа ББСБ-ууд (мянган төгрөгөөр).....	16
Хүснэгт 19 Ногоон зээлийн тайлан (сая төгрөгөөр).....	18
Хүснэгт 20 Факторингийн тооцооны авлагын ангилал (сая төгрөгөөр).....	19
Хүснэгт 21 Бусад хөрөнгийн бүтэц (сая төгрөгөөр).....	20
Хүснэгт 22 Үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, түрээсийн хөрөнгө, биет бус хөрөнгийн бүтэц (сая төгрөгөөр).....	20
Хүснэгт 23 Пассивын үзүүлэлтүүд (сая төгрөгөөр).....	21
Хүснэгт 24 Итгэлцлийн үйлчилгээ (сая төгрөгөөр).....	23
Хүснэгт 25 Банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг (сая төгрөгөөр).....	23
Хүснэгт 26 Бусад эх үүсвэрийн бүтэц (сая төгрөгөөр).....	23
Хүснэгт 27 Төслийн зээл санхүүжилт (сая төгрөгөөр).....	25
Хүснэгт 28 Бусад өр төлбөр (сая төгрөгөөр).....	25
Хүснэгт 29 Санхүүгийн бус өр төлбөр (сая төгрөгөөр).....	26
Хүснэгт 30 Өөрийн хөрөнгийн бүтэц (тэрбум төгрөгөөр).....	26
Хүснэгт 31 Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц (сая төгрөгөөр).....	26
Хүснэгт 32 ХНХ-ийн интервал (тэрбум төгрөгөөр).....	27
Хүснэгт 33 Бусад өмч, сангуудын бүтэц (сая төгрөгөөр).....	27
Хүснэгт 34 Орлого, үр дүнгийн тайлан (харьцуулсан, сая төгрөгөөр).....	29
Хүснэгт 35 Орлого, үр дүнгийн тайлан (тэр төгрөгөөр).....	29
Хүснэгт 36 Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд (үзүүлэлт бүрээр).....	30
Хүснэгт 37 2025 оны II улирлын байдлаарх валют арилжааны мэдээ (сая төгрөгөөр).....	31

Зургийн жагсаалт

Зураг 1 Банкны салбарт эзлэх хувь (нийт актив, зээл).....	11
Зураг 2 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр).....	11
Зураг 3 Мөнгөн хөрөнгийн бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр).....	12
Зураг 4 Зээлийн багцын чанар (тэрбум төгрөгөөр).....	14
Зураг 5 Зээлийн багцын чанар (хувиар)	14
Зураг 6 Олгосон зээл (хугацааны ангиллаар).....	16
Зураг 7 Ногоон зээлийн багцын чанар (ногоон таксономийн 12 ангиллаар).....	19
Зураг 8 Банкны салбарт эзлэх хувь (өөрийн хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгө, хуримтлагдсан ашиг).....	21
Зураг 9 Пассивын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр).....	22
Зураг 10 Итгэлцлийн үйлчилгээний өглөг (тэрбум төгрөгөөр).....	22
Зураг 11 Өрийн бичгийн үлдэгдэл сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр)	24
Зураг 12 Төслийн зээлийн санхүүжилт сүүлийн 5 жилийн байдлаар	24
Зураг 13 Хувьцаат капитал сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр).....	27
Зураг 14 Хуримтлагдсан ашиг/алдагдал (тэрбум төгрөгөөр).....	28
Зураг 15 Тайлант үеийн ашиг/алдагдал (тэрбум төгрөгөөр).....	28
Зураг 16 Ашигт ажиллагааны үзүүлэлт (тэрбум төгрөгөөр).....	29
Зураг 17 Салбарын өгөөжийн үзүүлэлт сүүлийн 5 жилээр	31

Товчилсон нэрсийн жагсаалт

Товчилсон нэр	Тайлбар
Хороо	Санхүүгийн зохицуулах хороо
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
СМА	Санхүүгийн мэдээллийн алба
ЗГВА	Гадаад валют арилжаа дагнан эрхэлдэг
УБ	Улаанбаатар хот
ХОН	Хөдөө орон нутаг
ГХО	Гадаадын хөрөнгө оруулалттай
ХНХ	Хувь нийлүүлсэн хөрөнгө
БХХО	Богино хугацаат хөрөнгө оруулалт
ӨБҮХХ	Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө
ӨБХ	Өмчлөх бусад хөрөнгө
ЗЖДХ	Зээлийн жигнэсэн дундаж хүү
ЗХШҮ	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт
СТ	Санхүүгийн тайлан
ХБҮЦ	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас
ЗМС	Зээлийн мэдээллийн сан

Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал

2025 оны II улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 573 ББСБ байгаа нь өмнөх оны мөн үеэс 24 ББСБ буюу 4.4 хувиар өссөн үзүүлэлт юм. Эдгээр ББСБ-уудын 95 нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа бол гадаадын хөрөнгө оруулалттай 28 ББСБ, олон нийтэд хувьцаагаа санал болгосон 5 ББСБ байна.

Хүснэгт 1 ББСБ-уудын тоо мэдээлэл

	2021-II	2022-II	2023-II	2024-II	2025-II
Шинээр олгосон	7	11	19	33	5
Хүчингүй	3	18	8	13	5
Түдгэлзүүлсэн	1	41	2	11	23
Сэргээсэн	5	9	16	12	2
Нийт ББСБ	536	527	522	549	573
Үүнээс: ХОН	79	89	95	99	95
Үүнээс: ГХО	30	27	25	26	28
Салбар	308	405	445	455	561
Төлөөлөгч	8	7	9	12	11

2025 оны II улирлын байдлаар 5 хуулийн этгээдэд шинээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон бол 23 ББСБ-ын үйл ажиллагааг түдгэлзүүлж, 2 ББСБ-ын үйл ажиллагааг сэргээж, 5 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна.

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгохоос гадна уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй онлайн зээлийн үйлчилгээг 2025 оны II улирлын байдлаар 72 ББСБ үзүүлж байна.

Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан ерөнхий үзүүлэлтүүд (тэрбум төгрөгөөр)

Үзүүлэлтүүд	2024-II	2025-II	Өсөлтийн хувь
Нийт хөрөнгө	5,756.6	7,983.4	38.7%
Банкны салбартай харьцуулахад хувиар	9.3%	11.0%	1.7%
Нийт өөрийн хөрөнгө	3,174.7	4,225.3	33.1%
Банкны салбартай харьцуулахад хувиар	52.5%	59.2%	6.7%
Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	1,682.2	1,980.5	17.7%
Банкны салбартай харьцуулахад хувиар	101.6%	109.0%	7.4%
Нийт зээл	4,590.5	6,674.9	45.4%
Банкны салбартай харьцуулахад хувиар	13.6%	15.6%	2.0%
Нийт орлого	800.9	1,264.9	57.9%
Нийт зарлага	475.8	807.2	69.6%
Цэвэр ашиг	325.1	457.7	40.8%

ББСБ-уудын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 38.7 хувиар өсөж, банкны салбарын 11.0%-тай тэнцэж байна. Харин хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ банкны салбарын 109.0%-тай тэнцэж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.3 пунктээр өссөн дүн юм.

2025 оны II улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагын салбарын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 38.7 хувиар буюу 2.2 их наяд төгрөгөөр өсөж 8.0 их наяд төгрөгт хүрсэн байна. Активын өсөлтийн 93.6 хувийг зээлийн өсөлт, пассивын өсөлтийн 47.2 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ББСБ-уудын нийт орлогын хэмжээ 57.9 хувиар буюу 464.0 тэрбум төгрөгөөр, нийт зардлын хэмжээ 69.6 хувиар буюу 331.4 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 40.8 хувиар буюу 132.6 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын тоо		Өөрчлөлт	
		2024-II	2025-II	Тоо	Хувь
	Нийт ББСБ-ын тоо	549	573	24	4.4%
1	Зээл	486	510	24	4.9%
	<i>Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг</i>	297	308	11	3.7%
2	Факторингийн үйлчилгээ	57	58	1	1.8%
3	Төлбөрийн баталгаа гаргах	28	29	1	3.6%
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	6	7	1	16.7%
5	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	51	55	4	7.8%
6	Гадаад валютын арилжаа	173	178	5	2.9%
	<i>Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг</i>	60	60	-	-
7	Итгэлцлийн үйлчилгээ	85	92	7	8.2%
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэл хөрөнгө оруулалт хийх	42	54	12	28.6%
9	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	1	1	-	-

Үйл ажиллагааны төрлөөр авч үзвэл 573 ББСБ 9 төрлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхэлж байна. Нийт ББСБ-уудын 89.0% нь буюу 510 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа ба үүнээс 60.4% нь буюу 308 ББСБ дагнан эрхэлж байна. Харин гадаад валютын

арилжааны үйл ажиллагаа эрхэлж байгаа 178 ББСБ байгаа нь нийт ББСБ-уудын 31.1 хувийг, гадаад валютын арилжааны үйл ажиллагаа дагнан эрхэлж байгаа 60 ББСБ нийт ББСБ-уудын 10.5 хувийг бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үеэс өөрчлөгдсөн үйл ажиллагааны төрлийг авч үзвэл зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг ББСБ-ын тоо өмнөх оноос 24 ББСБ-аар буюу 4.9 хувиар, гадаад валютын арилжаа 5 ББСБ-аар буюу 8.8 хувиар, итгэлцлийн үйлчилгээ 7 ББСБ-аар буюу 8.2 хувиар, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээ 12 ББСБ-аар буюу 28.6 хувиар, цахим төлбөр

тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ 4 ББСБ-аар буюу 7.8 хувиар өссөн бол факторингийн үйлчилгээ 5 ББСБ-аар буюу 8.8 хувиар, төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагаа 1 ББСБ-аар буюу 3.6 хувиар тус тус өссөн байна.

2025 оны II улирлын тайлан мэдээний ирц 100.0% байна. Тайлан мэдээг ирүүлбэл зохих 573 ББСБ-аас 573 ББСБ жилийн тайлан мэдээ ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 8 ББСБ өмнөх үеийн тайлан тэнцлээр, нэр бүхий 3 ББСБ эхлэлтийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа.

Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт, хэрэгжилт

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 68 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ыг, хоёрдугаар хавсралтаар “Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэхэд мөрдөх журам”-ыг тус тус баталсан. Энэхүү журмаар банк бус санхүүгийн итгэлцлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын хувьд итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн өглөгийг өөрийн хөрөнгөд харьцуулсан харьцаа нь 60 хувиас хэтрэхгүй байх, нийт зээлийн багцад эзлэх ногоон зээлийн хэмжээ хоёроос дээш хувь бол итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн өглөгийг өөрийн хөрөнгөд харьцуулсан харьцаа нь 65-80 хувь хүртэл байх, бусдаас өрийн бичиг гаргах замаар эх үүсвэр татан төвлөрүүлсэн ББСБ-ын хувьд гаргасан өрийн бичгийг өөрийн хөрөнгөд харьцуулсан харьцаа нь 30 хувиас хэтрэхгүй байх, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргасан ББСБ-ын хувьд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах замаар эх үүсвэр татан төвлөрүүлэх дүн нь өөрийн хөрөнгийн 60 хувиас хэтрэхгүй байх, мөн ББСБ нь дотоодын арилжааны банк, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч этгээдээс зээл болон бусад хэлбэрээр эх үүсвэр татан төвлөрүүлэхгүй байхаар зохицуулсан.

2. Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 77 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам”-д, 78 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-д тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан. Журмын өөрчлөлтийн хүрээнд ББСБ-аас олгох хэрэглээний зээлд өр, орлогын харьцаа 60 хувиас хэтрэхгүй байхаар, суудлын автомашин барьцаалсан зээл, зээл үнэлгээний харьцаа 60 хувиас хэтрэхгүй байхаар тус тус өөрчлөлт оруулсан.

3. 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр тусгай зөвшөөрөлтэй нийт 300 ББСБ-уудад Санхүүгийн зохицуулах хорооноос авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээ буюу нэмэлт, өөрчлөлт орсон журмуудын талаар танилцуулах сургалт зохион байгуулсан.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт

2025 оны II улирлын байдлаар Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т заасны дагуу 2025 оны хагас жилийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулах үүргийг 92.6 хувь буюу 529 ББСБ, нийтэд мэдээлэх үүргийг 89.1 хувь буюу 509 ББСБ хэрэгжүүлсэн байна.

Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилт

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ууд нь Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд шаардлагатай мэдээллийг өгөх, авах, гэрээ байгуулж мэдээлэл солилцох үүрэгтэй.

2025 оны II улирлын байдлаар зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 510 ББСБ-ын 97.8 хувь буюу 499 ББСБ Монголбанк, “Бүрэн скор ЗМС” ХХК болон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК-ийн аль нэгтэй гэрээ байгуулсан байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Энэ хуулийн 4.1-д

заасан этгээд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй.” гэж заасны дагуу нэр бүхий 98 ББСБ, 15,712 удаагийн тохиолдлоор, 1,546.4 тэрбум төгрөгийг, 7.2-т “Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ хуулийн 4.1-д заасан этгээд энэ тухай 24 цагийн дотор сэжигтэй гүйлгээний тухай батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ” гэж заасны дагуу нэр бүхий 9 ББСБ, 259 удаагийн тохиолдлоор, 27.9 тэрбум төгрөгийг Монголбанкны СМА-нд тус тус мэдээлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн байна.

“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт

2025 оны II улирлын байдлаар нийт 573 ББСБ-аас 1,471.49 сая төгрөгийн зохицуулалт үйлчилгээний хөлс төвлөрүүлэхээс 97.7% буюу 559 ББСБ 1,473.37 сая төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооны холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.

Статистик үзүүлэлтүүд

2025 оны II улирлын байдлаар давхардсан тоогоор 36,348 хувьцаа эзэмшигчдийн 573 ББСБ, 561 салбар нэгж, 11 төлөөлөгчийн газар, 6,412 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 8 дүүрэгт давхардсан тоогоор 3.6 сая харилцагч, 2.8 сая зээлдэгчид хүрч үйлчилж байна.

Харилцагчид, зээлдэгчид

Нийт харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 25.9 хувиар буурч давхардсан тоогоор 3,611,895-д, зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 49.4 хувиар өсөж 2,788,075-д хүрсэн байна.

Хүснэгт 4 Харилцагч, зээлдэгчдийн мэдээлэл

Статистик мэдээлэл	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Нийт харилцагчдын тоо	3,611,895	2,679,569	320,964	3,290,931	60,995	3,554,495	57,400	454,022	165,658
Үүнээс: Эмэгтэй	1,848,034	1,377,413	164,815	1,683,219	22,795	1,818,023	30,011	244,015	84,678
Эрэгтэй	1,750,776	1,300,498	144,483	1,606,293	28,045	1,723,484	27,292	209,323	80,488
Хуулийн этгээд	13,085	1,658	11,666	1,419	10,155	12,988	97	684	492
Итгэмжлэгчдийн тоо	13,648	13,646	1,372	12,276	-	13,604	44	6,590	319
Өрийн бичиг авсан харилцагчдын тоо	1,797	1,744	156	1,641	-	1,797	-	755	-
Зээлдэгчдийн тоо	2,788,075	2,060,687	151,052	2,637,023	44	2,734,039	54,036	289,013	165,656
Хэвийн	2,427,720	1,804,793	125,807	2,301,913	19	2,385,473	42,247	240,469	143,955
Хугацаа хэтэрсэн	129,142	93,279	5,695	123,447	-	125,968	3,174	18,904	9,312
Чанаргүй:	231,213	162,615	19,550	211,663	25	222,598	8,615	29,640	12,389
-Хэвийн бус	87,394	61,234	3,478	83,916	4	84,567	2,827	13,025	5,239
-Эргэлзээтэй	67,500	46,560	2,580	64,920	1	64,690	2,810	11,106	5,138
-Муу	76,319	54,821	13,492	62,827	20	73,341	2,978	5,509	2,012
Зээлдэгчдийн насжилт	2,785,645	2,059,310	149,590	2,636,055	44	2,731,695	53,950	288,572	165,164
18-25 насны	600,092	430,017	17,329	582,763	24	589,776	10,316	50,425	27,278
26-35 насны	1,064,000	758,027	46,406	1,017,594	20	1,039,488	24,512	114,465	66,526
36-45 насны	731,924	565,125	49,704	682,220	-	720,217	11,707	80,485	45,387
46-55 насны	318,019	247,640	26,796	291,223	-	312,289	5,730	32,795	18,945
55-аас дээш	71,610	58,501	9,355	62,255	-	69,925	1,685	10,402	7,028
Зээлдэгчдийн боловсрол	2,785,645	2,059,310	149,590	2,636,055	44	2,731,695	53,950	288,572	165,164
-Дээд	1,534,824	1,132,467	71,910	1,462,914	30	1,510,639	24,185	168,029	110,134
-Тусгай дунд	250,855	174,084	9,072	241,783	14	245,733	5,122	32,735	23,024
-Бүрэн дунд	689,032	517,272	44,727	644,305	-	666,904	22,128	68,564	20,246
-Дунд	239,130	180,857	16,338	222,792	-	237,419	1,711	15,653	8,016
-Бага	71,805	54,631	7,543	64,262	-	71,001	804	3,592	3,745

(Финтек ББСБ-ууд финтек уламжлалт зээл хослуулан олгодог болно)

Нийт харилцагчдын 91.1% буюу 3,290,931 нь зээлдэгчдийн 88.5% буюу 2,466,888 нь санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж (финтек), онлайн зээлийн үйлчилгээ нэвтрүүлж буй ББСБ-уудын харилцагч, зээлдэгч байгаа бол нийт харилцагчдын 8.9% буюу 320,964 нь зээлдэгчдийн 11.5% буюу 321,187 нь уламжлалт ББСБ-ын харилцагч, зээлдэгч байна. Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг ББСБ-уудын харилцагчид 60,995 буюу нийт харилцагчдын 1.7 хувийг бүрдүүлж байна.

Хувьцаа эзэмшигчид болон ажилчид

Хүснэгт 5 Статистик мэдээлэл (5 жилээр)

Үзүүлэлтүүд	2021-II	2022-II	2023-II	2024-II	2025-II	Өөрчлөлт	
						Дүнгээр	Хувиар
Хувьцаа эзэмшигчдийн тоо	21,486	22,378	28,366	33,910	36,348	2,438	7.2%
Ажилчдын тоо	3,713	4,279	5,012	5,575	6,412	837	15.0%
Харилцагчдын тоо	3,292,164	4,748,336	3,895,981	4,875,687	3,611,895	(1,263,792)	(25.9%)
Зээлдэгчдийн тоо	74,827	1,518,497	1,322,326	1,865,966	2,788,075	922,109	49.4%
Зээлийн жигнэсэн дундаж хүү	2.9%	3.1%	3.3%	3.5%	3.6%	0.1%	

Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо өмнөх оны мөн үеэс 7.2 хувиар буюу 2,438-аар өсөж 36,348-г хүрчээ. Нийт хувьцаа эзэмшигчдийн 96.8 хувь буюу 35,188 нь олон нийтэд хувьцаагаа санал болгосон ББСБ-уудын хувьцаа эзэмшигч байгаа бол 1,160 буюу 3.2% нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчид байна. Мөн хувьцаа эзэмшигчдийн 3,099 буюу 8.5% нь гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын хувьцаа эзэмшигчид байгаа бол 213 буюу 0.6% нь хөдөө орон нутгийн ББСБ-уудын хувьцаа

эзэмшигчид байна. ББСБ-ын салбарын нийт ажилтнуудын тоо өмнөх оны мөн үеэс 15.0 хувиар буюу 837 ажилтнаар нэмэгдэж 6,412-д хүрсэн байна.

Хүснэгт 6 ББСБ-ын мэдээлэл

Статистик мэдээлэл	НИЙТ	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Хувьцаа эзэмшигчдийн тоо	36,348	35,434	1,957	34,391	81	36,135	213	35,206	3,099
Нийт ажилтнуудын тоо	6,412	4,073	2,852	3,560	147	6,117	295	579	499
Үүнээс: Эмэгтэй ажилтны тоо	3,913	2,446	1,743	2,170	79	3,715	198	365	325
Эрэгтэй ажилтны тоо	2,499	1,627	1,109	1,390	68	2,402	97	214	174

Хөдөө орон нутгийн 95 ББСБ 7 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байна.

Хүснэгт 7 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа

	НИЙТ	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
ТЗ-тэй ББСБ-ын тоо	573	92	501	72	60	478	95	5	568	28
1 Зээл	510	92	438	72	0	419	91	5	505	27
2 Факторингийн үйлчилгээ	58	35	32	26	0	54	4	3	55	1
3 Төлбөрийн баталгаа гаргах	29	16	20	9	0	28	1	3	26	3
4 Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	7	6	0	7	0	7	0	1	6	0
5 Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	55	27	31	24	0	53	2	3	52	2
6 Гадаад валютын арилжаа	178	38	148	30	60	162	16	5	173	9
7 Итгэлцлийн үйлчилгээ	92	92	53	39	0	88	4	5	87	5
8 Богино хугацааг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	54	34	34	20	0	51	3	3	51	4
9 Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	1	1	1	0	0	1	0	0	1	1

Тархалт

Улаанбаатар хотод нийт ББСБ-уудын 83.4% буюу 478 ББСБ, салбаруудын 60.1% буюу 337 салбар байршиж байна. Харин хөдөө орон нутагт нийт ББСБ-ын 16.6% буюу 95 ББСБ, салбаруудын 39.9% буюу 223 салбар бүртгэлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.

2025 оны II улирлын байдлаар 118 ББСБ-ын 561 салбар бүртгэлтэй байгаа ба эдгээрийн 56.0 хувийг 14 ББСБ-ын 314 салбар бүрдүүлж байна. Монголын ББСБ-уудаас анх удаа гадаад улсад албан ёсны салбараа нээлээ. Зээл, гадаад валют арилжаа болон цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй “Эдванс кредит ББСБ” ХХК нь 2024 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 342 дугаар тушаалаар Австрали улсын Брисбэн хотод салбартай болсон байна.

Хүснэгт 8 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт

Дүүрэг	Үндсэн	Салбар	Нийт	Хувь
	478	337	815	100.0%
1. Сүхбаатар	158	44	202	24.8%
2. Чингэлтэй	130	31	161	19.8%
3. Баянзүрх	56	86	142	17.4%
4. Баянгол	65	43	108	13.3%
5. Хан-Уул	60	49	109	13.4%
6. Сонгинохайрхан	8	72	80	9.7%
7. Багануур	1	7	8	1.0%
8. Налайх	-	5	5	0.6%

ББСБ-ууд хөдөө орон нутгаас Орхон, Төв, аймгуудад, Улаанбаатар хотоос Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүдэд хамгийн ихээр төвлөрч үйлчилгээгээ хүргэж байна.

Хүснэгт 9 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт

Аймаг	Үндсэн	Салбар	Нийт	Хувь
	95	223	318	100%
Архангай аймаг	2	7	9	2.8%
Баян-Өлгий аймаг	3	5	8	2.5%
Баянхонгор аймаг	4	11	15	4.7%
Булган аймаг	2	2	4	1.3%
Говь-Алтай аймаг	1	2	3	0.9%
Говьсүмбэр аймаг	3	4	7	2.2%
Дархан-Уул аймаг	9	20	29	9.1%
Дорноговь аймаг	2	12	14	4.4%
Дорнод аймаг	5	20	25	7.9%
Дундговь аймаг	-	8	8	2.5%
Завхан аймаг	2	7	9	2.8%
Орхон аймаг	9	21	30	9.4%
Өвөрхангай аймаг	11	15	26	8.2%
Өмнөговь аймаг	2	21	23	7.2%
Сүхбаатар аймаг	5	7	12	3.8%
Сэлэнгэ аймаг	8	13	21	6.6%
Төв аймаг	19	9	28	8.8%
Увс аймаг	2	9	11	3.5%
Ховд аймаг	1	8	9	2.8%
Хөвсгөл аймаг	2	11	13	4.1%
Хэнтий аймаг	3	11	14	4.4%

Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт


2025 оны II улирлын байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 8.0 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 38.7 хувиар буюу 2.2 их наяд төгрөгөөр өсжээ. Активын өсөлтийн 93.6 хувийг цэвэр зээлийн өсөлт бүрдүүлж байна. Активын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл:

Хүснэгт 10 Активын үзүүлэлтүүд (сая төгрөгөөр)

Активын үзүүлэлтүүд	2024-II		2025-II		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
САНХҮҮГИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5,490,485.7	95.4%	7,615,980.8	95.4%	2,125,495.0	38.7%
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	706,663.0	12.3%	664,243.2	8.3%	-42,419.8	-6.0%
Хөрөнгө оруулалт	76,956.9	1.3%	96,943.3	1.2%	19,986.4	26.0%
Зээл (цэврээр)	4,558,254.8	79.2%	6,588,311.9	82.5%	2,030,057.1	44.5%
Факторингийн тооцооны авлага (цэврээр)	21,896.9	0.4%	58,669.2	0.7%	36,772.3	167.9%
Үүсмэл санхүүгийн хөрөнгө	1,333.6	0.0%	4,791.2	0.1%	3,457.7	259.3%
Бусад санхүүгийн хөрөнгө	125,380.5	2.2%	203,021.9	2.6%	77,641.4	61.9%
САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	266,099.7	4.6%	367,401.2	4.6%	101,301.5	38.1%
Санхүүгийн бус бусад хөрөнгө	99,178.4	1.7%	155,275.7	1.9%	56,097.3	56.6%
Үндсэн хөрөнгө (цэврээр)	124,020.7	2.2%	159,565.9	2.0%	35,545.2	28.7%
Биет бус хөрөнгө (цэврээр)	42,900.6	0.7%	52,559.6	0.7%	9,659.0	22.5%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,756,585.4	100%	7,983,382.0	100%	2,226,796.5	38.7%


2025 оны II улирлын байдлаар ББСБ-уудын нийт актив банкны салбарын нийт активын 11.0 хувьтай, нийт зээлийн үлдэгдэл 15.6 хувьтай тэнцэж байна.

Зураг 1 Банкны салбарт эзлэх хувь (нийт актив, зээл)



Сүүлийн 5 жилийн активын үзүүлэлтийг харвал салбарын нийт актив 2020 оны II улиралд 1,862.2 тэрбум төгрөг байсан бол 2025 оны II улирлын байдлаар 4.3 дахин өсөж 7,983.4 тэрбум төгрөгт хүрчээ. Энэ нь нийт зээлийн үлдэгдэл 5.1 дахин өссөнтэй холбоотой.

Зураг 2 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр)



Салбарын нийт хөрөнгийн 98.3% нь 2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хөрөнгөтэй 411 ББСБ, 0.6% нь 1.9-2.5 тэрбум төгрөг хүртэлх активтай 20 ББСБ байгаа бол нийт салбарын хөрөнгийн 1.1 хувийг 1.9 тэрбум төгрөг хүртэлх активтай 142 ББСБ-ын хөрөнгө бүрдүүлж байна.

Хүснэгт 11 Активын интервал (тэрбум төгрөгөөр)

Интервал	Нийт		Эзлэх хувь		Дархан, Эрдэнэт		Бусад аймаг, сумд		ЗГВА	
	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо
5.0 тэрбумаас дээш	7,063.8	177	88.5%	30.9%	28.9	3	19.9	3	-	-
2.5-5.0 тэрбум	786.3	234	9.8%	40.8%	3.8	1	8.4	2	5.7	2
1.9-2.5 тэрбум	45.4	20	0.6%	3.5%	-	-	5.9	3	2.1	1
1.4-1.9 тэрбум	24.9	15	0.3%	2.6%	6.2	4	6.7	4	4.9	3
0.6-1.4 тэрбум	32.0	35	0.4%	6.1%	9.2	10	14.8	16	6.6	8
0.6 тэрбум хүртэлх	30.9	92	0.4%	16.1%	-	-	15.1	49	16.6	46
НИЙТ	7,983.4	573	100.0%	100.0%	48.1	18	70.7	77	35.8	60

Салбарын хамгийн өндөр активтай 20 ББСБ-ын актив 4.6 их наяд төгрөг байгаа нь нийт активын 58.0 хувийг, нийт зээлийн үлдэгдэл 4.0 их наяд төгрөг байгаа нь нийт зээлийн үлдэгдлийн 60.0 хувийг бүрдүүлж байна.

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө


Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 42.4 тэрбум төгрөгөөр буюу 6.4 хувиар буурч 664.1 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Бүтцээр нь авч үзвэл 15.8 хувь нь бэлэн мөнгө хэлбэрээр, 66.9 хувь нь 3 хүртэлх сарын хугацаатай банк, санхүүгийн байгууллагад, 15.9 хувь нь 3-аас дээш сарын хугацаатай банк, санхүүгийн байгууллагад, 1.4 хувь нь мөнгөн хөрөнгөд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага байна.

Хүснэгт 12 Мөнгөн хөрөнгийн бүтэц (тэрбум төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	664.2	373.3	330.9	333.4	32.8	648.1	16.1	93.2	84.5
Бэлэн мөнгө	104.7	11.3	97.6	7.1	22.6	98.9	5.8	2.8	3.7
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө (3 хүртэлх сарын хугацаатай)	444.6	281.9	179.0	265.7	9.5	437.4	7.2	84.7	77.8
Мөнгөн хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	9.3	7.2	4.6	4.6	0.1	9.2	0.0	-	-
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө (3-аас дээш сарын хугацаатай)	105.7	72.9	49.7	56.0	0.5	102.5	3.2	5.7	3.0

ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн бүтцийг авч үзвэл уламжлалт үйл ажиллагаа явуулж байгаа ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 29.5%, финтек ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 2.1%, эрхэлж буй үйл ажиллагааны онцлогоос хамаарч гадаад валютын арилжаа дагнан эрхэлж буй ББСБ-уудын 69.0% нь бэлэн мөнгө хэлбэрээр тус тус байршиж байна.

Зураг 3 Мөнгөн хөрөнгийн бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр)



Хөрөнгө оруулалт

Хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 26.0 хувиар буюу 20.0 тэрбум төгрөгөөр өсөж, 2025 оны II улирлын байдлаар 44 ББСБ 96.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан байна. Хөрөнгө оруулалтын 2.3 хувь буюу 2.2 тэрбум төгрөг нь хадгаламжийн сертификат, 97.7 хувь буюу 94.7 тэрбум төгрөг нь үнэт цаасаарх хөрөнгө оруулалт байна.

Хүснэгт 13 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц (сая төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэл	Уламж- лалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	96,943.3	89,913.4	26,516.7	70,426.6	1.0	95,872.3	1,071.1	54,042.0	42,711.8
Хадгаламжийн сертификат	2,216.6	2,215.6	2,100.8	115.8	-	2,216.6	-	-	-
Үнэт цаас	94,726.7	87,697.7	24,415.9	70,310.8	1.0	93,655.7	1,071.1	54,042.0	42,711.8
Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлэх үнэт цаас	38,434.7	32,408.9	19,829.9	18,604.7	1.0	37,363.6	1,071.1	4,080.0	500.0
Хорогдуулсан өртгөөр илэрхийлсэн үнэт цаас	12,260.4	11,860.4	3,189.8	9,070.6	-	12,260.4	-	7,830.4	-
Бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлэх үнэт цаас	43,593.0	43,391.2	833.8	42,759.2	-	43,593.0	-	42,409.2	42,611.0
Барьцаанд байгаа үнэт цаас	399.4	1.0	399.4	-	-	399.4	-	-	-
Үнэт цаасанд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	663.4	660.3	163.0	500.4	-	663.4	-	346.5	224.9
(Үнэт цаасны эрсдэлийн сан)	624.2	624.2	-	624.2	-	624.2	-	624.2	624.2

2025 оны II улирлын байдлаар богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх зөвшөөрөлтэй 54 ББСБ бүртгэлтэй байгаа хэдий ч 44 ББСБ санхүүгийн тайлангаар хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан ба эдгээрийн 33 ББСБ нь тусгай зөвшөөрөлтэй байна.

Засгийн газрын бондыг эрсдэлгүй гэж үзэн СЗХ-оос тухайн төрлийн бондыг тусгай зөвшөөрөлгүйгээр авах боломжтой гэж үзсэн хэдий ч санхүүгийн тайлангийн Засгийн газрын үнэт цаас хэсэгт бүртгэсэн дүн байхгүй байна. Иймээс 7 ББСБ тусгай зөвшөөрөлгүй энэхүү үйл ажиллагааг эрхэлсэн байгаа тул Зөрчлийн тухай хуульд заасны дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

Зээл

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 45.4 хувь буюу 2.1 их наяд төгрөгөөр өсөж 2025 оны II улирлын байдлаар 6.7 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд үүнд 357.5 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 6.6 их наяд төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт 14 Зээлийн бүтэц (тэрбум төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Зээл (цэврээр)	6,588.3	5,061.0	2,373.4	4,214.9	2.3	6,498.3	90.0	1,104.8	821.3
Зээл	6,946.4	5,310.1	2,506.1	4,440.3	2.3	6,850.9	95.5	1,175.5	871.4
Хэвийн	5,828.6	4,514.3	2,103.0	3,725.6	1.8	5,748.4	80.2	967.8	706.8
Анхаарал хандуула	332.4	266.8	93.1	239.2	-	329.2	3.2	80.6	68.3
Чанаргүй зээл	513.9	354.4	192.5	321.4	0.1	505.0	8.9	88.4	67.1
-Хэвийн бус зээл	194.5	145.8	57.5	137.0	0.1	191.0	3.5	43.0	29.1
-Эргэлзээтэй зээл	135.7	96.2	43.2	92.5	0.0	133.4	2.3	29.0	21.3
-Муу зээл	183.7	112.3	91.7	92.0	0.1	180.6	3.1	16.4	16.7
(ЗЭС)	357.5	249.1	132.1	225.4	0.1	352.0	5.5	70.7	50.1
Хойшлогдсон төлбөр	4.1	4.0	1.1	3.0	-	4.1	-	2.9	2.9
Зээлд хур/тооцсон хүүгийн авлага	275.7	178.6	118.6	157.1	0.4	272.5	3.2	41.6	32.1
ЗЗ-ийн хүүнээс доогуур хүүтэйгээ олгосон зээлийн бодит үнийн залруулга	0.6	-	0.6	-	-	0.6	-	-	-


(Финтек ББСБ-ууд уламжлалт зээл давхар олгодог болно)

Шинэчлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн журамд зааснаар “Санхүүгийн тайланд зээлийг хорогдуулсан өртгөөр хэмжисж, тайлагнана. Зээлийн хорогдуулсан өртөг нь

зээлийг анх хүлээн зөвшөөрч хэмжсэн дүнгээс буцаан төлсөн зээлийн үндсэн төлбөрийн төлөлтийг хасаж, хойшлогдсон орлого, зардлыг үр ашигт хүүгийн аргаар хорогдуулан хуримтлуулсан дүнг хасах, эсхүл нэмж, зээлийн эрсдэлийн санг хассан дүн байна” гэж тодорхойлсон.

Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг 1 ББСБ нь 44 зээлдэгчид 1.9 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй гарсан ба нэр бүхий ББСБ-ын зээлийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг 2024.03.20-ны өдрийн 119 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон байна. Тайлант хугацаанд ББСБ-ууд 7.4 их наяд төгрөгийн зээлийг 3.6 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр олгож, 6.5 их наяд төгрөгийн зээлэргэн төлөгдөж, 2025 оны II улирлын байдлаар 2.6 сая зээлдэгчийн 6.7 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.


Зураг 4 Зээлийн багцын чанар (тэрбум төгрөгөөр)



(Нийт зээлийн үлдэгдлийг зээлийн багцын нийлбэрээр тооцсон)

Зээлийн багцын 87.3 хувийг буюу 5.8 их наяд төгрөгийг хэвийн зээл, 5.0 хувийг буюу 332.4 тэрбум төгрөгийг анхаарал хандуулах зээл, 7.7 хувийг буюу 514.0 тэрбум төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Зураг 5 Зээлийн багцын чанар (хувиар)



Нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 3.5 пунктээр буурсан бол, чанаргүй зээлийн хэмжээ 1.5 пунктээр анхаарал хандуулах зээл 2.0 пунктээр тус тус өссөн байна. Анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн 846.3 тэрбум төгрөгийн үлдэгдлийн 42.2 хувьд буюу 357.5 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан байна.

2025 оны II улирлын байдлаар нийт зээлд эзлэх анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн хэмжээ 12.7% байна.

Олгосон зээлийн 92.9 хувь буюу 6.9 их наяд төгрөгийн зээлийг иргэдэд, 7.1 хувь буюу 528 тэрбум төгрөгийн зээлийг хуулийн этгээдэд олгосон байгаа бол 94.0 хувь буюу 6.1 их наяд төгрөг нь иргэдээс, 6.0 хувь нь буюу 390.2 тэрбум төгрөг нь хуулийн этгээдээс эргэн төлөгдсөн байна.

2025 оны II улирлын байдлаар 6.7 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа ба үүний 89.4 хувь буюу 6.0 их наяд төгрөгийг иргэдийн, 10.6 хувь буюу 706.4 тэрбум төгрөгийг хуулийн этгээдийн зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.


Хүснэгт 15 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар (сая төгрөгөөр)

№	Зээлийн эдийн засгийн ангилал	Олгосон зээл		Төлөгдсөн зээл		Зээлийн үлдэгдэл	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1.	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	42,303.9	0.6%	28,025.5	0.4%	71,133.5	1.1%
2.	Уул уурхай, олборлолт	36,473.4	0.5%	36,056.9	0.6%	84,889.3	1.3%
3.	Боловсруулах үйлдвэрлэл	37,519.6	0.5%	26,232.9	0.4%	61,944.0	0.9%
4.	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	7,540.1	0.1%	5,399.7	0.1%	12,041.6	0.2%
5.	Ус хангамж; сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэнбуй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	3,523.9	0.0%	2,821.9	0.0%	7,002.1	0.1%
6.	Барилга	192,799.6	2.6%	160,635.3	2.5%	345,842.7	5.2%
7.	Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	521,100.0	7.0%	418,113.1	6.4%	773,121.1	11.6%
8.	Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	155,665.9	2.1%	151,119.1	2.3%	213,749.8	3.2%
9.	Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	58,497.3	0.8%	53,281.3	0.8%	124,957.8	1.9%
10	Мэдээлэл, холбоо	11,153.9	0.2%	12,845.7	0.2%	34,432.5	0.5%
11	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	103,686.2	1.4%	76,051.8	1.2%	99,407.3	1.5%
12	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	82,702.2	1.1%	64,026.2	1.0%	88,760.8	1.3%
13	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	4,244.8	0.1%	3,795.3	0.1%	11,116.6	0.2%
14	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	9,503.1	0.1%	9,166.8	0.1%	20,811.2	0.3%
15	Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	5,037.7	0.1%	6,427.9	0.1%	12,992.3	0.2%
16	Боловсрол	28,164.4	0.4%	23,560.9	0.4%	36,011.3	0.5%
17	Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	16,368.2	0.2%	12,813.7	0.2%	30,037.2	0.5%
18	Урлаг, үзвэр, тоглоом наадам	5,791.4	0.1%	2,317.0	0.0%	9,678.7	0.1%
19	Бусад	6,106,210.6	82.2%	5,411,196.2	83.2%	4,636,951.0	69.5%
	<i>Иргэнд олгосон зээл</i>	6,900,258.9	92.9%	6,113,687.9	94.0%	5,968,463.4	89.4%
	<i>Хуулийн этгээдэд олгосон зээл</i>	528,027.4	7.1%	390,199.3	6.0%	706,417.4	10.6%
	НИЙТ	7,428,286.2	100.0%	6,503,887.2	100%	6,674,880.9	100%

Сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны дарга нарын хамтарсан 2018 оны 12-р сарын 31-ний өдрийн 319/А/16 тоот тушаалаар баталсан “[Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал](#)”-аар нийт олгосон зээлийн 82.2% буюу 6.1 их наяд төгрөг нь бусад ангилалд (ихэвчлэн хэрэглээний зээл), 7.0% буюу 521.1 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгогдсон бол нийт төлөгдсөн зээлийн 83.2% буюу 5.4 их наяд төгрөг нь бусад ангиллын зээлээс, 6.4% буюу 418.1 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгосон зээлээс эргэн төлөгджээ.

Тайлант улиралд олгосон зээлийг хугацааны ангиллаар харвал 1 сар хүртэлх хугацаатай олгосон зээл нийт зээлийн 25.5 хувийг, 6-12 сарын хугацаатай олгосон зээл нийт зээлийн 22.3 хувийг, 1-2.5 жил, 2.6-5 жил хүртэлх хугацаатай олгосон зээл тус тус нийт зээлийн 14.2 хувийг буюу хамгийн өндөр хувийг бүрдүүлж байна.

Зураг 6 Олгосон зээл (хугацааны ангиллаар)



Нийт зээлийн үлдэгдлийн ангиллаас харахад 6.7 их наядын зээлийн 55.2 хувийг иргэний хэрэглээний зээлийн үлдэгдэл, үүнээс 24.3 хувийг автомашинд зориулсан зээлийн үлдэгдэл, 9.1 хувийг хуулийн этгээдийн бизнесийн зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Хүснэгт 16 Зээлийн ангилал (тэрбум төгрөгөөр)

Зээлийн ангиллаар	Олгосон зээл		Төлөгдсөн зээл		Зээлийн үлдэгдэл	
	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь
Иргэнд олгосон зээл	6,900.3	92.9%	6,113.7	94.0%	5,968.5	89.4%
Хэрэглээнд зориулсан зээл	4,848.2	65.3%	4,526.0	69.6%	3,684.8	55.2%
Үүнээс: Автомашинд зориулсан зээл	668.4	9.0%	590.7	9.1%	1,625.0	24.3%
Бизнес зориулсан зээл	999.4	13.5%	733.5	11.3%	1,253.8	18.8%
Үл хөдлөх эд хөрөнгөд зориулсан зээл	74.1	1.0%	69.4	1.1%	217.2	3.3%
Бусад зээл	978.5	13.2%	784.8	12.1%	812.6	12.2%
Хуулийн этгээдэд олгосон зээл	528.0	7.1%	390.2	6.0%	706.4	10.6%
Бизнесийн зээл	429.1	5.8%	310.0	4.8%	609.8	9.1%
Автомашинны зээл	2.6	0.0%	5.1	0.1%	10.0	0.2%
Үл хөдлөх эд хөрөнгийн зээл	15.8	0.2%	11.2	0.2%	13.9	0.2%
Бусад зээл	80.5	1.1%	63.9	1.0%	72.7	1.1%
НИЙТ	7,428.3	100%	6,503.9	100%	6,674.9	100%

Цахим зээл

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгон, уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй 72 ББСБ 66 финтек зээлийн аппликэйшнээр дамжуулж цахим зээлийн үйлчилгээ үзүүлж байна.

Хүснэгт 17 Зээлийн ангилал (мянган төгрөгөөр)

	Зээлийн дүн	Нийт дүнд эзлэх хувь	Зээлдэгчдийн тоо	Нийт дүнд эзлэх хувь	Дундаж зээл
Уламжлалт	4,808,749,452.6	72.0%	321,187	11.5%	14,971.8
Цахим зээл	1,866,131,410.7	28.0%	2,466,888	88.5%	756.5
Нийт	6,674,880,863.4	100.0%	2,788,075	100.0%	2,394.1

2025 оны II улирлын байдлаар эдгээр ББСБ-ууд зөвхөн аппликэйшний 2.5 сая зээлдэгчийн 1.9 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа нь нийт зээлдэгчийн 88.5 хувь, нийт зээлийн үлдэгдлийн 28.0 хувийг бүрдүүлж байна. Зөвхөн аппликэйшнээр нэг зээлдэгчид дунджаар 756.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь уламжлалт зээлийн дунджаас 19.8 дахин бага байна. Цахим зээлийн мэдээлэл ирүүлээгүй 18 ББСБ-уудад холбогдох арга хэмжээг авах шаардлагатай байна.

Хүснэгт 18 Цахим зээл олгож байгаа ББСБ-ууд (мянган төгрөгөөр)

№	Финтек	Апп нэр	Бүртгүүлсэн огноо	Зээлийн дүн	Зээлдэгчдийн тоо	Дундаж зээл
1	Соно финтек	Sono Mongolia	2023.03.03 №7/895	194,047,758.7	498,337	389.4
2	Покет	Pocket.mn	2023.05.08 №7/1871	168,073,447.2	191,514	877.6
3	Тус финтек	Tus fintech	2023.05.19 №7/2125	84,604,999.6	263,079	321.6
4	Мобифинанс	Monpay	2023.06.20 №7/2540	84,067,537.9	210,821	398.8
5	Анлок капитал	Unlock Finance	2024.04.23 №7/1442	11,349,626.2	25,322	448.2
6	Жи Би Си Си	E-zeel	2023.03.03 №7/889	498,874.6	915	545.2
7	Нөмөр кредит	Numur	2023.03.03 №7/890	142,474,619.3	126,611	1,125.3
8	Энт кредит инвестмент	EntCreditMN	2023.03.03 №7/891	3,519,983.3	12,513	281.3
9	Хатан суудал инвест	Zeely	2023.03.03 №7/894	17,816,738.8	93,540	190.5
10	Онч-Энх	Ugloo	2023.03.30 №7/1297	34,120.3	157	217.3
11	Гэрэлфинанс	Gerel	2023.05.08 №7/1872	8,711,290.5	25,260	344.9
12	Цогзолфинанс	Pocket.mn	2023.05.23	5,690,221.1	14,237	399.7
13	Мөнгөнзоос кредит	Pocket.mn	2023.05.24	6,621,917.2	15,267	433.7

14	Финрүүт-Инвестмент	Pocket.mn	2023.05.24	2,359,554.3	5,653	417.4
15	Инвексор	Pocket.mn	2023.05.25	129,001,038.7	138,722	929.9
16	ТОКИ	Toki	2023.06.20 №7/2549	106,708,055.8	155,663	685.5
17	Лэндмн	LendMN	2023.06.20 №7/2550	275,871,778.4	76,319	3,614.7
18	Хас хаан	ХАСХААН	2023.06.20 №7/2551	1,660,870.1	1,419	1,170.5
19	Ньюстар финанс	Nsf.mn	2023.06.20 №7/2552	10,115,391.2	25,477	397.0
20	Сэндли	Sendly	2023.07.04 №7/2821	27,152,854.0	21,760	1,247.8
21	Нанокапитал	Nano Capital	2023.07.04 №7/2824	171,819.1	709	242.3
22	Нэт капитал финанс корпораци	NetPay	2023.07.04 №7/2825	33,472,453.6	103,372	323.8
23	Таван богд финанс	PayOn.mn	2023.07.04 №7/2826	232,957,976.2	105,712	2,203.7
24	Грийн-Инвестмент	Gate.mn	2023.07.04 №7/2827	2,323,745.8	6,200	374.8
25	Омни капитал	Moni	2023.07.05 №7/2869	33,259,717.3	48,532	685.3
26	Инвеско фонд	IF.mn	2023.08.25 №7/3349	310,969.9	1,192	260.9
27	Очир ундраа ОМЗ	Opay MN	2023.08.25 №7/3351	9,118,065.1	7,251	1,257.5
28	Бизнес-Инвест девелопмент	BiD	2023.08.25 №7/3353	9,823,436.7	8,796	1,116.8
29	Монголиа импакт финанс	Qmoni	2023.08.25 №7/3356	172,968.2	400	432.4
30	Ашид капитал	Simple.mn	2023.11.10 №7/4317	149,511,165.4	49,369	3,028.4
31	Соломон инвестментс	M credit	2023.11.10 №7/4319	16,463,293.8	53,629	307.0
32	Сэнд эм эн	Pocket.mn	2023.12.20	4,696,348.0	10,098	465.1
33	Изи пэй норбула	Easypay.mn	2023.12.22 №7/4867	383,415.3	72	5,325.2
34	Дэвжих нэхий	Money-T	2023.12.22 №7/4870	9,546,008.0	16,072	594.0
35	Микрокредит	Easy	2023.12.22 №7/4871	1,743,583.4	340	5,128.2
36	Хангууд финанс	Khanguud	2023.12.22 №7/4872	23,761.3	69	344.4
37	Ардкредит	Ard	2023.12.22 №7/4873	39,834,993.8	31,742.00	1,255.0
38	Жи Эс Би Капитал	Prime	2024.02.21 №7/631	12,970,587.2	37,361.00	347.2
39	Кэйш флов финанс	Tugrug App	2024.02.21 №7/632	4,805,326.2	28,845.00	166.6
40	Их монгол кредит	Ikh Mongol Credit	2024.02.21 №7/633	893,896.2	594.00	1,504.9
41	Магна профит энд инвестмэнт	Magna.mn	2024.02.21 №7/635	2,055.1	2.00	1,027.6
42	Централ капитал	Kmobimn	2024.04.23 №7/1441	549,601.5	1,693.00	324.6
43	Си и си инвестмент	Pocket.mn	2024.04.24	8,731,871.9	21,916.00	398.4
44	Их ирээдүй капитал	Easy loan	2024.05.30 №7/2043	540,659.1	195.00	2,772.6
45	Девелопинг энтэрпрениориа монголиа	DEM.mn	2024.05.30 №7/2045	438,909.4	470.00	933.8
46	Алтан зоос капитал	ZOOS	2024.05.30 №7/2046	1,216,462.3	5,022.00	242.2
47	Төвхөн ингүүмэл	Oneclick.mn	2024.07.09 №7/2534	1,558,756.5	5,804.00	268.6
48	Өсөх ундарга финанс	Ufinance	2024.09.23 №7/3171	153,228.1	314.00	488.0
49	Финко капитал	Beer	2024.09.23 №7/3172	1,162,562.0	503.00	2,311.3
50	Хексинг финанс	Sign Finance	2024.12.04 №7/3980	96,930.6	240.00	403.9
51	Балансэд кредит	Balance	2024.12.04 №7/3981	2,704,353.2	794.00	3,406.0
52	Вишинфанд	Вишинфанд	2024.12.04 №7/3982	236,878.0	311.00	761.7
53	Үнэт кредит	M credit	2024.12.05	50,195.5	388.00	129.4
54	Улаанбаатар кредит	Uray	2024.12.16 №7/4110	69,843.0	81.00	862.3
55	Навитас фонд	Pocket.mn	2025.02.03	Мэдээлэл ирүүлээгүй		
56	Мэйн стрит финанс	Pays	2025.02.11 №3/425			
57	Есөн эрдэнэ финанс	Leasing.mn	2023.03.30 №7/1298			
58	Гурван зуун жар финанс	Minu pay	2023.07.04 №7/2822			
59	Франкфурт капитал	Nar app	2023.07.04 №7/2823			
60	Зээл Эм Эн платформ	Zeel.mn	2023.07.04 №7/2828			
61	Есөн финанс	MetaLend	2023.08.25 №7/3352			
62	Говьфинанс	CashOne	2023.08.25 №7/3354			
63	Гоулдман инвестмент групп	Goldpay	2023.08.25 №7/3355			
64	Номин юнити	OmniWay	2024.02.21 №7/634			
65	Дарь финанс	Pocket.mn	2024.03.01			
66	Прогресс финтек	Zuut	2024.05.30 №7/2044			
67	Эм Эл Жи финанс Юү Би	ANDA	2024.07.09 №7/2536			
68	Монголиан юнайтед кредит	UniPay.mn	2024.12.04 №7/3979			
69	Монголын ногоон санхүүгийн корпораци	Мост мони	2024.12.25			
70	БСБ финанс	BSB Finance	2025.02.11 №3/427			
71	Монкор финанс	Cash pay	2025.04.15 №3/1391			
72	Тапапэй	Tapa	2025.05.01 №3/1631			
72				1,866,131,410.7	2,466,888	756.5

*/"Инвексор ББСБ" ХК-ийн Pocket аппликэйшнд бүртгэлтэй 9 ББСБ байна.
Зөвхөн аппликэйшнээр зээл олгож байгаа 5 ББСБ-ыг шараар тэмдэглэв/*

2025 оны II улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хороонд финтек зээлийн бүтээгдэхүүн бүртгүүлсэн 72 ББСБ байна.

Ногоон зээл

Тайлант хугацаанд 32 ББСБ 5,568 зээлдэгчид 82.1 тэрбум төгрөгийн зээлийг дунджаар 3.0 хувийн хүүтэйгээр олгож, 38 ББСБ-ын 8,820 зээлдэгчээс 48.0 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2025 оны II улирлын байдлаар 40 ББСБ 10,993 зээлдэгчийн 143.4 тэрбум төгрөгийн “ногоон” зээлийн үлдэгдэлтэй гарчээ. Энэ нь салбарын нийт зээлийн үлдэгдлийн 2.1%-тай тэнцэж байна.


Хүснэгт 19 Ногоон зээлийн тайлан (сая төгрөгөөр)

НОГООН ТАКСОНОМИ ҮНДСЭН 12 АНГИЛАЛ	Олгосон зээлийн		Төлөгдсөн зээлийн		Зээлийн эцсийн үлдэгдлийн	
	Дүн	Зээлдэгчдийн тоо	Дүн	Зээлдэгчдийн тоо	Дүн	Зээлдэгчдийн тоо
1. Эрчим хүчний хангамж, дэд бүтэц	123.3	25	539.6	22	473.0	33
2. Эрчим хүчний үр ашиг	7,757.1	3,026	5,792.6	3,254	12,658.6	5,438
3. Тогтвортой хот төлөвлөлт ба барилга	5,929.1	156	8,290.9	618	21,484.8	1,289
4. Бохирдлыг бууруулах ба сэргийлэх	110.8	17	121.0	2	123.3	23
5. Тогтвортой ус, хог хаягдал	1,538.1	27	288.5	9	1,781.1	17
6. Тогтвортой хөдөө аж, ахуй	10,165.2	388	4,460.7	387	12,696.9	604
7. Тогтвортой газар ашиглалт ба биологийн олон янз байдал	736.2	40	271.1	38	1,129.1	46
8. Нүүрс хүчлийн хийн ялгарал багатай тээвэр	39,949.3	1,456	24,330.9	4,192	66,656.8	3,059
8.1.Цахилгаан тээврийн хэрэгсэл	6,017.5	42	3,991.9	349	9,006.8	221
8.2.Хосолсон хөдөлгүүрт тээврийн хэрэгсэл	29,888.7	1,310	17,540.1	2,350	46,551.8	2,424
8.3.Хэмнэлттэй тээврийн хэрэгсэл	571.5	2	886.3	1,429	9,533.8	354
8.4.Дугуй, скүүтэр	0.0	0	0.7	0	4.5	2
8.5.Бусад	3,471.5	102	1,911.8	64	1,559.7	58
9. Мэдээлэл, харилцаа холбоо, технологи	2,110.4	54	943.1	51	1,209.8	54
10. Эрүүл мэнд	9,910.0	220	1,695.7	118	9,524.7	238
11. Боловсрол, Соёл	3,632.4	156	1,266.7	129	6,944.8	191
12. Хүртээмжтэй дэд бүтэц	142.3	3	0.0	0	8,704.0	1
НИЙТ	82,104.2	5,568	48,000.8	8,820	143,386.9	10,993

Ногоон зээлийн үлдэгдлийн 46.5% буюу 66.7 тэрбум төгрөгийг нүүрс хүчлийн хийн ялгарал багатай тээврийн салбарт олгосон зээлийн үлдэгдэл, 15.0% буюу 21.5 тэрбум төгрөгийг тогтвортой хот төлөвлөлт ба барилгын салбарт олгосон зээлийн үлдэгдэл, 8.8% буюу 12.7 тэрбум төгрөгийг эрчим хүчний хангамж, дэд бүтцийн салбарт олгосон зээлийн үлдэгдэл, 8.9% буюу 12.7 тэрбум төгрөгийг тогтвортой хөдөө аж, ахуй салбарт олгосон зээлийн үлдэгдэл, 6.6% буюу 9.5 тэрбум төгрөгийг эрүүл мэнд ангиллын салбарт олгосон зээлийн үлдэгдэл, болон 14.2% буюу 20.6 тэрбум төгрөгийг бусад ангиллын салбарт олгосон зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 89.9% буюу 128.9 тэрбум төгрөг нь хэвийн, 6.2% буюу 8.9 тэрбум төгрөг нь анхаарал хандуулах, 3.9% буюу 5.6 тэрбум төгрөг нь чанаргүй ангилалд ангилагдсан байна.

Зураг 7 Ногоон зээлийн багцын чанар (ногоон таксономийн 12 ангиллаар)



Факторингийн тооцооны авлага

Факторингийн тооцооны авлага өмнөх оны мөн үеэс 177.3 хувиар буюу 40.5 тэрбум төгрөгөөр өсөж, 21 ББСБ 63.3 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ. 2025 оны II улирлын байдлаар 663.6 сая төгрөгийн факторингийн тооцооны хүүгийн авлага хуримтлуулан бүртгэсэн нь өмнөх мөн үетэй харьцуулахад 56.1 хувиар буурсан байна. Нийт 12.2 тэрбум төгрөгийн анхаарал хандуулах болон чанаргүй факторингийн үлдэгдэлд 4.6 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 58.7 тэрбум төгрөгийн цэвэр үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 20 Факторингийн тооцооны авлагын ангилал (сая төгрөгөөр)

Нийт факторингийн тооцооны авлага	2024-II		2025-II		Өөрчлөлт	
	Нийт дүн	Эзлэх хувь	Нийт дүн	Эзлэх хувь		
Нийт факторингийн тооцооны авлага	22,838.0	100.0%	63,321.6	100.0%	40,483.6	177.3%
Хэвийн	19,715.0	86.3%	50,434.4	79.6%	30,719.4	255.8%
Анхаарал хандуулах	505.5	2.2%	3,829.2	6.0%	3,323.7	657.4%
Чанаргүй	1,105.9	4.8%	8,394.4	13.3%	7,288.4	759.0%
Хэвийн бус	239.0	1.0%	2,976.8	4.7%	2,737.8	1145.7%
Эргэлзээтэй	147.6	0.6%	3,401.6	5.4%	3,254.0	2204.4%
Муу	719.4	3.1%	2,016.0	3.2%	1,296.6	280.2%
(Факторингийн авлагын эрсдэлийн сан)	941.1	4.1%	4,652.4	7.3%	3,711.3	494.3%
Факторингийн тооцооны хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	1,511.5	6.6%	663.6	1.0%	(847.9)	-56.1%

Факторингийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад буурсан ба факторингийн тусгай зөвшөөрөлтэй 55 ББСБ-уудаас 21 ББСБ нь тайлант хугацаанд факторингийн үйл ажиллагаа эрхэлсэн байна.

Үүсмэл санхүүгийн хөрөнгө, бусад санхүүгийн хөрөнгө

2025 оны II улирлын байдлаар 4 ББСБ 4.8 тэрбум төгрөгийн своп арилжаа хийсэн байна.

Бусад санхүүгийн хөрөнгө өмнөх оны мөн үеэс 61.9 хувь буюу 77.6 тэрбум төгрөгөөр өсөж 203.0 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 21 Бусад хөрөнгийн бүтэц (сая төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэл -тэй	Уламж- лалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Үүсмэл санхүүгийн хөрөнгө	4,791.2	4,791.2	1,180.3	3,610.9	-	4,791.2	-	201.4	201.4
Своп арилжаа	4,791.2	4,791.2	1,180.3	3,610.9	-	4,791.2	-	201.4	201.4
Бусад санхүүгийн хөрөнгө	203,021.9	145,907.4	65,890.0	137,131.9	300.0	200,280.7	2,741.2	61,423.6	29,860.5
Авлага (цэвэр дүнгээр)	157,903.4	114,666.8	51,816.0	106,087.5	300.0	155,334.2	2,569.2	55,450.6	24,691.9
Салбар хоорондын тооцоо	22,608.8	21,288.0	1,203.2	21,405.6	-	22,568.8	40.0	965.9	-
Өмчлөх бусад хөрөнгө – санхүүгийн хөрөнгө (цэвэр дүнгээр)	4,194.1	916.7	4,127.2	66.8	-	4,194.1	-	-	79.0
Бусад	15,451.1	6,171.3	8,743.6	6,707.5	-	15,319.2	131.9	5,007.2	5,089.6

Санхүүгийн бус хөрөнгө

ББСБ-ууд 2025 оны II улирлын байдлаар 222.3 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлд 62.7 тэрбум төгрөгийн элэгдэл байгуулж, 1.4 сая төгрөгийн үнэ цэнийн бууралтыг бүртгэсэн байгаа бол 80.2 тэрбум төгрөгийн биет бус хөрөнгийн үлдэгдэлд 27.6 тэрбум төгрөгийн хорогдол байгуулсан байна.

Ингэснээр тайлант хугацаанд 159.5 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө, 52.6 тэрбум төгрөгийн биет бус хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт 22 Үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, түрээсийн хөрөнгө, биет бус хөрөнгийн бүтэц (сая төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, түрээсийн хөрөнгө, биет бус хөрөнгө	212,125.5	145,017.3	79,217.6	132,908.0	479.4	208,738.4	3,387.2	21,748.1	18,653.2
Үндсэн хөрөнгө (цэврээр)	59,565.9	108,386.1	70,048.4	89,517.6	476.4	156,402.6	3,163.3	16,766.3	15,806.0
Барилга, байгууламж	74,127.1	56,093.6	26,407.7	47,719.4	81.3	72,663.4	1,463.7	5,315.2	7,721.2
Компьютер, дагалдах хэрэгсэл	13,398.3	9,074.6	5,167.9	8,230.3	28.4	12,934.2	464.0	1,394.8	1,393.2
Тээврийн хэрэгсэл	41,353.3	18,516.4	28,563.4	12,789.9	290.7	40,597.3	755.9	1,485.9	1,885.3
Тавилга, эд хогшил	17,452.5	12,108.2	7,744.8	9,707.7	67.5	17,090.4	362.1	1,371.7	1,507.7
Түрээсийн хөрөнгө	9,408.6	9,399.1	893.1	8,515.5	0.0	9,399.1	9.5	6,276.1	3,062.1
Борлуулаад буцаан түрээслэсэн хөрөнгө	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бусад үндсэн хөрөнгө	3,826.2	3,194.3	1,271.5	2,554.8	8.5	3,718.1	108.1	922.6	236.6
Биет бус хөрөнгө (цэврээр)	52,559.6	36,631.2	9,169.2	43,390.4	3.0	52,335.8	223.8	4,981.8	2,847.1
Зохиогчийн эрх	9.1	0.0	0.0	9.1	0.0	0.0	9.1	0.0	0.0
Програм хангамж	31,834.2	25,792.0	3,525.8	28,308.4	3.0	31,644.3	189.9	4,728.8	2,843.4
Мэдээллийн сан	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Патент	996.0	1.5	996.0	0.0	0.0	996.0	0.0	0.0	0.0
Барааны тэмдэг	45.7	21.2	0.0	45.7	0.0	45.7	0.0	0.0	0.0
Тусгай зөвшөөрөл	20.7	0.0	0.0	20.7	0.0	20.7	0.0	0.0	0.0
Газар эзэмших эрх	1,478.8	1,341.0	1,400.0	78.8	0.0	1,466.0	12.9	0.0	0.0
Ашиглах эрхтэй хөрөнгө	10,550.5	9,089.7	2,790.5	7,760.0	0.0	10,538.5	12.0	252.9	0.0
Бусад биет бус хөрөнгө	7,624.6	385.8	457.0	7,167.7	0.0	7,624.6	0.0	0.1	3.8

Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт

Салбарын нийт пассив өмнөх оны мөн үеэс 38.7 хувиар буюу 2.2 их наяд төгрөгөөр өссөн ба энэхүү өсөлтийн 52.8 хувийг өр төлбөрийн өсөлт, 47.2 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна. Пассивын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл:


Хүснэгт 23 Пассивын үзүүлэлтүүд (сая төгрөгөөр)

Пассивын үзүүлэлтүүд	2024-II	Нийт дүнд	2025-II	Нийт дүнд	Өөрчлөлт	
	дүн	эзлэх хувь	дүн	эзлэх хувь	дүн	хувь
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	2,581,865.5	44.9%	3,758,040.2	47.1%	1,176,174.8	45.6%
САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	2,384,203.9	41.4%	3,510,968.9	44.0%	1,126,765.0	47.3%
Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр	884,846.9	15.4%	1,175,282.7	14.7%	290,435.8	32.8%
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	871,874.0	15.1%	1,419,483.0	17.8%	547,608.9	62.8%
Бусад эх үүсвэр	471,107.7	8.2%	672,962.0	8.4%	201,854.3	42.8%
Үүсмэл санхүүгийн өр төлбөр	412.8	0.0%	3,475.1	0.1%	3,062.3	741.9%
Бусад санхүүгийн өр төлбөр	155,009.4	2.7%	229,148.5	2.9%	74,139.2	47.8%
Хоёрдогч өглөг	953.1	0.0%	10,617.6	0.1%	9,664.5	1014.0%
Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)	-	-	-	-	-	-
САНХҮҮГИЙН БУС ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	197,661.6	3.4%	247,071.4	3.1%	49,409.8	25.0%
ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,174,719.9	55.1%	4,225,341.7	52.9%	1,050,621.8	33.1%
Хувь нийлүүлсэн хөрөнгө	1,682,159.5	29.2%	1,980,466.2	24.8%	298,306.7	17.7%
Нэмж төлөгдсөн капитал	82,034.7	1.4%	102,796.0	1.3%	20,761.3	25.3%
Халаасны хувьцаа	-2,548.0	0.0%	-2,580.2	-0.03%	-32.2	1.3%
Үндсэн хөрөнгө, биет бус ХДҮН	13,862.1	0.2%	22,523.9	0.3%	8,661.8	62.5%
Хуримтлагдсан ашиг, алдагдал	1,329,168.8	23.1%	2,010,746.2	25.2%	681,577.5	51.3%
Бусад өмч	70,042.8	1.2%	111,389.6	1.4%	41,346.8	59.0%
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5,756,585.4	100%	7,983,382.0	100%	2,226,796.5	38.7%

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад өр төлбөрөөс итгэлцлийн үйлчилгээний өглөг 1.3 дахин, банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр 1.6 дахин, бусад эх үүсвэр 1.4 дахин, үүсмэл санхүүгийн өр төлбөр 8.4 дахин, бусад санхүүгийн өр төлбөр 1.5 дахин, барагдуулах ёстой хоёрдогч өглөгийн өр төлбөр 11.1 дахин өссөн бол өөрийн хөрөнгөөс хуримтлагдсан ашиг 51.3 хувиар, хувь нийлүүлсэн хөрөнгө 17.7 хувиар, нэмж төлөгдсөн капитал 25.3 хувиар тус тус өссөн байна. Мөн бусад өмчийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 1.6 дахин өссөнд хөрвөх нөхцөлтэй хоёрдогч өглөгийн үлдэгдэл болон итгэлцлийн үйл ажиллагааны нөөцийн сан хамгийн их нөлөөлж байна.


Салбарын сүүлийн 5 жилийн байдлаарх санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг банкны салбартай харьцуулбал 2020 оны II улирлын байдлаар өөрийн хөрөнгө банкны салбарын 43.8 хувьд хүрдэг байсан бол 2025 оны II улирлын байдлаар 59.2 хувьд хүрч байна. 2025 оны II улирлын байдлаар 573 ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ арилжааны 12 банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн 109.0 хувьтай тэнцэж байна. Хуримтлагдсан ашгийн хувьд өмнөх оны мөн үед 38.8 хувьтай тэнцдэг байсан бол 2025 оны II улирлын байдлаар 7.4 пунктээр өсөж 46.2 хувьтай тэнцэж байна.

Зураг 8 Банкны салбарт эзлэх хувь (өөрийн хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгө, хуримтлагдсан ашиг)



Сүүлийн 5 жилийн пассивын үзүүлэлтийг харвал 2025 оны II улирлын байдлаар салбарын нийт өөрийн хөрөнгийн хэмжээ 2020 онтой харьцуулахад 3.1 дахин өсөж 4.2 их наяд төгрөгт, өр төлбөрийн хувьд 7.2 дахин өсөж 3.8 их наяд төгрөгт хүрсэн байна.


Зураг 9 Пассивын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр)



Итгэлцлийн үйлчилгээний өглөг

2025 оны II улирлын байдлаар итгэлцлийн үйлчилгээний өглөг өмнөх оны мөн үеэс 1.3 дахин буюу 290.4 тэрбум төгрөгөөр өсөж, итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй 92 ББСБ-аас 86 ББСБ 13,648 итгэмжлэгчээс 1,175.3 тэрбум төгрөгийн итгэлцэл татан төвлөрүүлсэн байна.

Зураг 10 Итгэлцлийн үйлчилгээний өглөг (тэрбум төгрөгөөр)



Нийт татан төвлөрүүлсэн итгэлцлийн өглөгийн 58.8 хувийг иргэдээс, 35.7 хувийг хувийн байгууллагаас татан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацаанд 1,116.0 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлж үүнд 59.6 тэрбум төгрөгийн үр шим хуримтлуулан тооцож бүртгэсэн байна.

Хүснэгт 24 Итгэлцлийн үйлчилгээ (сая төгрөгөөр)

	Дүн	Хувь	Итгэл-цэлтэй	Уламж-лалт	Финтек	УБ	ХОН	ХК	ГХО
Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр	1,175,282.7	100%	1,174,932.7	220,705.2	954,577.5	-	1,167,735.9	7,546.8	304,318.8
Хувийн байгууллага	419,763.8	35.7%	419,413.8	52,233.5	367,530.3	-	415,809.8	3,954.0	162,870.7
Иргэд	690,769.5	58.8%	690,769.5	158,121.4	532,648.1	-	687,695.6	3,074.0	120,454.9
Өрх гэр, иргэдэд үйлчлэгч ашгийн бус байгууллага (Улс төрийн нам, сүм хийд)	-	0.0%	-	-	-	-	-	-	-
Эдийн засгийн харьяат бус	5,412.8	0.5%	5,412.8	-	5,412.8	-	5,412.8	-	-
Итгэлцлээр татсан хөрөнгөнд хуримтлуулж тооцсон үр шим	59,648.4	5.1%	59,648.4	10,350.2	49,298.1	-	59,129.6	518.8	21,304.9
Итгэлцлээр татсан хөрөнгийн хойшлогдсон төлбөр	311.8	0.0%	311.8	-	311.8	-	311.8	-	311.8
Нийт итгэмжлэгчдийн тоо	13,648		13,646	1,372	12,276	-	13,604	44	6,590

Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр

2025 оны II улирлын байдлаар дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.6 дахин өсөж, 119 ББСБ дотоод, гадаадын банк болон санхүүгийн байгууллагаас 1,419.5 тэрбум төгрөгийн эх үүсвэр татан төвлөрүүлж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Хүснэгт 25 Банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг (сая төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэл-тэй	Уламж-лалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	1,419,483.0	1,195,945.2	399,744.7	1,019,738.2	248.4	1,417,632.5	1,850.4	447,633.1	341,396.9
Авсан зээл	1,392,577.6	1,178,626.1	396,689.2	995,888.4	248.4	1,390,727.2	1,850.4	439,268.8	336,456.0
Дотоодын	668,699.6	537,135.9	160,464.3	508,235.3	248.4	667,499.2	1,200.4	211,062.3	171,504.7
Гадаадын	379,179.0	376,416.0	57,750.3	321,428.7	-	379,179.0	-	198,255.9	164,951.3
Бусад	344,880.7	265,255.9	178,474.6	166,406.1	-	344,230.7	650.0	29,950.7	-
Бодит үнэ цэнийн залруулга	181.7	181.7	-	181.7	-	181.7	-	-	-
Хугацаа хэтрэлт	278.3	-	-	278.3	-	278.3	-	-	-
Дотоодын	-	-	-	-	-	-	-	-	-
Гадаадын	278.3	-	-	278.3	-	278.3	-	-	-
Бусад	-	-	-	-	-	-	-	-	-
Бодит үнэ цэнийн залруулга									
Хойшлогдсон төлбөр	2,111.7	2,111.7	672.6	1,439.1	-	2,111.7	-	1,439.1	1,370.6
Дотоодын	68.4	68.4	-	68.4	-	68.4	-	68.4	-
Гадаадын	2,043.3	2,043.3	672.6	1,370.6	-	2,043.3	-	1,370.6	1,370.6
Бусад	-	-	-	-	-	-	-	-	-
Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	28,738.7	19,430.7	3,728.1	25,010.5	-	28,738.7	-	9,803.3	6,311.6
Дотоодын	12,509.1	4,347.1	1,171.0	11,338.1	-	12,509.1	-	1,242.6	1,123.3
Гадаадын	7,163.5	7,124.9	750.4	6,413.1	-	7,163.5	-	5,847.7	5,082.1
Бусад	9,066.1	7,958.7	1,806.7	7,259.4	-	9,066.1	-	2,713.1	106.2

Бусад эх үүсвэр

2025 оны II улирлын байдлаар 69 ББСБ 673.0 тэрбум төгрөгийн бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй гарчээ. Үүнээс давхардсан тоогоор 57 ББСБ 634.3 тэрбум төгрөгийн өрийн бичиг, 17 ББСБ 12.5 тэрбум төгрөгийн бусад эх үүсвэр, 2 ББСБ 919.5 сая төгрөгийн хойшлогдсон төлбөр, 53 ББСБ 25.3 тэрбум төгрөгийн бусад эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 26 Бусад эх үүсвэрийн бүтэц (сая төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэл-тэй	Уламж-лалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Бусад эх үүсвэр	672,962.0	632,500.1	118,833.5	554,128.5	-	672,921.7	40.4	125,843.1	59,935.2
Гаргасан өрийн бичиг	634,318.3	597,297.5	109,130.7	525,187.5	-	634,318.3	-	120,949.2	57,400.0
Гаргасан үнэт цаас	1,600.0	1,600.0	1,600.0	-	-	1,600.0	-	-	1,600.0
Төслийн зээлийн санхүүжилт	129.7	12.4	11.4	118.4	-	129.7	-	-	-
Бусад	12,499.8	12,215.8	1,584.8	10,915.0	-	12,459.8	40.0	3,492.7	-

Бусад эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр	919.5	919.5	-	919.5	-	919.5	-	919.5	607.5
Бусад эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	25,333.8	22,293.9	6,506.7	18,827.1	-	25,333.5	0.4	2,320.7	1,542.7

ББСБ-аас гаргасан өрийн бичиг

ББСБ-ууд өрийн бичиг гаргахдаа “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллах үүрэгтэй.


2025 оны II улирлын байдлаар биржийн бус зах зээл дээр 56 ББСБ 583,112.2 сая төгрөг татан төвлөрүүлсэн тухай тоо мэдээ ирүүлсэн байна. Үүнийг санхүүгийн тайланд тусгасан тоо мэдээтэй тулган баталгаажуулахад 3 ББСБ огт бүртгэлгүй санхүүгийн тайланд 17.1 тэрбум төгрөгийн бондын үлдэгдэл тусгасан байгаа тул журам зөрчсөн холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Биржийн бус зах зээлийн тоо мэдээнээс санхүүгийн тайланд тайлагнасан дүн зөрсөн 7 ББСБ байна. Үүнээс 6 ББСБ 7.1 тэрбум төгрөг дутуу тайлагнасан бол 1 ББСБ 2.8 тэрбум төгрөгийг илүү тайлагнасан буюу зөвшөөрөлгүйгээр эх үүсвэр татан төвлөрүүлж тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг санхүүжүүлсэн байна.

Биржийн зах зээл дээр 2025 оны II улирлын байдлаар 4 ББСБ 48.7 тэрбум төгрөгийг бондыг татан төвлөрүүлсэн байна.

57 ББСБ нээлттэй болон хаалттай хүрээнд 635.3 тэрбум төгрөгийн өрийн бичгийн үлдэгдэлтэй гарсан байгаа нь 2020 оны мөн үеэс 12.1 дахин өссөн үзүүлэлт юм.


Зураг 11 Өрийн бичгийн үлдэгдэл сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр)



Төслийн зээлийн санхүүжилт

Төсөл хөтөлбөрөөс 3 ББСБ 129.7 сая төгрөгийг татан төвлөрүүлж үйл ажиллагаандаа ашиглаж байна. Төслийн зээлийн санхүүжилт 2020 оны мөн үеэс 20.6 тэрбум төгрөг буюу 18 дахин, өмнөх оны мөн үеэс 18.2 тэрбум төгрөг буюу 15 дахин буурсан байна.

Зураг 12 Төслийн зээлийн санхүүжилт сүүлийн 5 жилийн байдлаар



Төслийн зээлийн санхүүжилтийг олгосон субъектээр нь ангилж харвал 15.8 хувь нь гадаадын төслийн, 84.2 хувь нь дотоодын санхүүжилттэй төслийн санхүүжилтийн зээл бүрдүүлж байна.

Хүснэгт 27 Төслийн зээл санхүүжилт (сая төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэл-тэй	Уламж-лалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Төслийн зээлийн санхүүжилт	129.7	12.4	11.4	118.4	-	129.7	-	-	-
Засгийн газрын санхүүжилттэй	-	-	-	-	-	-	-	-	-
Гадаадын санхүүжилттэй	20.5	-	-	20.5	-	20.5	-	-	-
Дотоодын санхүүжилттэй	109.3	12.4	11.4	97.9	-	109.3	-	-	-
Жижиг дунд үйлдвэрлэлийн төслийн санхүүжилтийн зээл	-	-	-	-	-	-	-	-	-
Бусад	-	-	-	-	-	-	-	-	-
Зах зээлийн хүүгийн түвшнээс өндөр буюу бага хүү бүхий зээлийн бодит үнэ цэнийн тохируулга	-	-	-	-	-	-	-	-	-

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ХБҮЦ)

2025 оны II улирлын байдлаар ББСБ-уудын гаргасан ХБҮЦ-ыг харвал 18-24 сарын хугацаатай, жилийн 17.0-20.0 хувийн хүүтэй, 6.0-50.0 тэрбум төгрөгийн буюу нийт 215 тэрбум төгрөгийн 7 ББСБ-ийн нээлттэй зах зээлд гаргасан ХБҮЦ байна.

Бусад санхүүгийн өр төлбөр

2025 оны II улирлын байдлаар 2 ББСБ 3.5 тэрбум төгрөгийн үүсмэл санхүүгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй, 96 ББСБ 229.5 тэрбум төгрөгийн бусад санхүүгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй, 3 ББСБ 10.6 тэрбум төгрөгийн хоёрдогч өглөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 28 Бусад өр төлбөр (сая төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Үүсмэл санхүүгийн өр төлбөр	3,475.1	3,475.1	65.5	3,409.6	-	3,475.1	-	-	-
Форвард арилжаа	-	-	-	-	-	-	-	-	-
Своп арилжаа	3,475.1	3,475.1	65.5	3,409.6	-	3,475.1	-	-	-
Опшин арилжаа	-	-	-	-	-	-	-	-	-
Фьючерс арилжаа	-	-	-	-	-	-	-	-	-
Бусад арилжаа	-	-	-	-	-	-	-	-	-
Бусад санхүүгийн өр төлбөр	229,148.5	191,988.4	50,752.1	178,396.4	520.5	228,738.0	410.5	72,075.5	50,894.9
Хоёрдогч өглөг	10,617.6	314.8	-	10,617.6	-	10,617.6	-	-	-
Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн бус өр төлбөр

Санхүүгийн бус өр төлбөрийн 61.5 хувийг бусад өр төлбөр, 22.2 хувийг тайлант үеийн орлогын албан татварын өглөг, 10.1 хувийг бусад татварын өглөг, 2.2 хувийг урьдчилж орсон орлого, 2.0 хувийг цалингийн өглөг, 2.0 хувийг бусад өглөг бүрдүүлж байна.

Хүснэгт 29 Санхүүгийн бус өр төлбөр (сая төгрөгөөр)

САНХҮҮГИЙН БУС ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	Дүн	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
	247,071.4	171,275.9	81,663.4	165,407.9	213.3	243,727.3	3,344.1	35,445.6	16,618.2
Цалингийн өглөг	4,995.3	4,011.8	1,030.2	3,965.1	35.4	4,964.5	30.8	1,349.9	1,158.6
ЭМ, НДШ-ийн өглөг	1,591.8	452.3	888.8	703.0	21.2	1,539.5	52.3	39.8	95.7
Тайлант үеийн орлогын албан татварын өглөг	54,940.3	40,059.6	17,344.9	37,595.4	24.1	54,479.0	461.4	8,222.8	3,666.4
Бусад татварын өглөг	24,919.0	18,270.9	9,074.5	15,844.4	92.3	24,640.7	278.3	2,451.8	1,219.8
Хойшлогдсон татварын өглөг	1,683.3	1,614.5	468.0	1,215.3	-	1,679.4	3.9	764.4	280.7
Хойшлогдсон орлого	1,637.8	1,626.1	1,457.2	180.6	-	1,637.8	-	-	-
Урьдчилж орсон орлого	5,357.3	1,451.3	982.9	4,374.4	-	5,351.6	5.7	453.9	19.8
Борлуулах зорилгоор эзэмшиж буй өр төлбөр	-	-	-	-	-	-	-	-	-
Бусад	151,906.9	103,751.1	50,378.6	101,528.3	40.3	149,395.2	2,511.7	22,163.0	10,177.3
Нөөц, болзошгүй өр төлбөр	39.6	38.2	38.2	1.4	-	39.6	-	-	-

Өөрийн хөрөнгө

ББСБ-уудын өөрийн хөрөнгө өмнөх оны мөн үеэс 33.1 хувиар буюу 1,050.6 тэрбум төгрөгөөр өсөж 4.2 их наяд төгрөгт хүрсэн нь нийт активын 52.9 хувийг бүрдүүлж байна. ББСБ-уудын өөрийн хөрөнгийн 46.9 хувийг хувь нийлүүлсэн хөрөнгө, 47.6 хувийг хуримтлагдсан ашиг, 5.5 хувийг өөрийн хөрөнгийн бусад хэсэг бүрдүүлж байна.

Хүснэгт 30 Өөрийн хөрөнгийн бүтэц (тэрбум төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Хувь нийлүүлсэн хөрөнгө	1,980.5	884.1	1,257.7	722.7	25.2	1,914.7	65.8	58.1	148.5
Нэмж төлөгдсөн капитал	102.8	102.6	18.2	84.6	0.1	102.7	0.1	68.6	49.0
Халаасны хувьцаа	2.6	2.6	0.2	2.4	-	2.6	-	2.4	0.0
Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	22.5	13.9	1.3	21.2	-	22.4	0.1	-	0.0
Хуримтлагдсан ашиг, алдагдал	2,010.7	1,452.8	844.8	1,165.9	9.6	1,972.4	38.3	238.7	162.0
Бусад өмч	111.4	106.1	12.9	98.5	-	110.0	1.4	15.9	6.9
ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,225.3	2,557.0	2,134.7	2,090.6	34.9	4,119.7	105.7	378.8	366.4
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	7,983.4	5,927.4	3,006.5	4,976.9	35.8	7,864.5	118.9	1,364.2	1,021.8
Нийт хөрөнгөд эзлэх хувь	52.9%	43.1%	71.0%	42.0%	97.3%	52.4%	88.9%	27.8%	35.9%

Хувь нийлүүлсэн хөрөнгө


Хувь нийлүүлсэн хөрөнгө нь өмнөх оны мөн үеэс 17.7 хувь буюу 298.3 тэрбум төгрөгөөр өсөж 2.0 их наяд төгрөгт хүрсэн байна.

Хүснэгт 31 Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц (сая төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Хувь нийлүүлсэн хөрөнгө	1,980,466.2	884,093.6	1,257,727.3	722,738.9	25,198.3	1,914,700.6	65,765.6	58,052.5	148,544.7
Давуу эрхийн хувьцаа (өөрийн хөрөнгө)	105,713.3	105,035.0	10,713.3	95,000.0	-	105,671.0	42.3	12,000.0	12,121.0
Энгийн хувьцаа - Хаалттай	1,828,700.4	733,006.1	1,240,974.0	587,726.5	25,198.3	1,762,977.1	65,723.3	-	113,189.7
Энгийн хувьцаа - Нээлттэй	46,052.5	46,052.5	6,040.0	40,012.5	-	46,052.5	-	46,052.5	23,234.0
Хоёрдогч өглөг (өөрийн хөрөнгө)	76,260.0	73,350.0	2,215.0	74,045.0	-	76,260.0	-	7,845.0	-
Хөрвөх өр төлбөр (өөрийн хөрөнгө)	-	-	-	-	-	-	-	-	-
Нэмж төлөгдсөн капитал	102,796.0	102,582.3	18,200.6	84,595.4	55.8	102,722.7	73.3	68,591.4	48,989.1
Давуу эрхийн хувьцаа	1.3	-	1.3	-	-	-	1.3	-	-
Энгийн хувьцаа	102,794.7	102,582.3	18,199.3	84,595.4	55.8	102,722.7	72.0	68,591.4	48,989.1
Халаасны хувьцаа	2,580.2	2,580.2	210.4	2,369.8	-	2,580.2	-	2,373.3	3.6
Давуу эрхийн хувьцаа	-	-	-	-	-	-	-	-	-
Энгийн хувьцаа	2,580.2	2,580.2	210.4	2,369.8	-	2,580.2	-	2,373.3	3.6

2025 оны II улирлын байдлаар 573 ББСБ-ын 1.9 их наяд төгрөгийн энгийн хувьцаа, 9 ББСБ-ын 105.7 тэрбум төгрөгийн давуу эрхийн хувьцаа, 4 ББСБ-ын 2.6 тэрбум төгрөгийн халаасны хувьцаа бүртгэгдсэн байна.

Зураг 13 Хувьцаат капитал сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр)



Салбарын хамгийн өндөр активтай 20 ББСБ-ын өөрийн хөрөнгийн хэмжээ 1.8 их наяд төгрөг байгаа нь нийт өөрийн хөрөнгийн 42.1 хувийг, бусдаас татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн дүн 2.5 их наяд төгрөг байгаа нь нийт дүнгийн 78.0 хувийг бүрдүүлж байна. ББСБ-уудын үйл ажиллагаа өргөжиж, томрохын хэрээр бусдаас эх үүсвэр татан төвлөрүүлэх боломж нь нэмэгдэж байгаа тул эдгээр ББСБ-уудын зайны болон газар дээрх хяналт шалгалтыг сайжруулах шаардлагатай байна.

Хүснэгт 32 ХНХ-ийн интервал (тэрбум төгрөгөөр)

Интервал	Нийт		Эзлэх хувь		Дархан, Эрдэнэт		Бусад аймаг, сумд		ЗГВА	
	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо
5.0 тэрбумаас дээш	951.1	82	48.0%	14.3%	7.3	1	6.9	1	0.0	0
2.5-5.0 тэрбум	962.9	344	48.6%	60.0%	5.8	2	5.0	2	0.0	0
1.9-2.5 тэрбум	3.9	2	0.2%	0.3%	0.0	0	0.0	0	3.9	2
1.4-1.9 тэрбум	9.0	6	0.5%	1.0%	1.5	1	6.1	4	1.4	1
0.6-1.4 тэрбум	21.9	25	1.1%	4.4%	11.5	14	6.5	7	2.9	3
0.6 тэрбум хүртэлх	31.7	114	1.6%	19.9%	0.0	0	15.2	63	17.0	54
НИЙТ	1,980.5	573	100.0%	100.0%	26.0	18	39.8	77	25.2	60

2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 426 ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 96.6% буюу 1.9 их наяд төгрөг байна. Харин 2.5 тэрбум төгрөг хүртэлх хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 147 ББСБ-ын 66.4 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгө салбарын нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 3.4 хувийг бүрдүүлж байна.

Өөрийн хөрөнгийн бусад хэсэг

2025 оны II улирлын байдлаар 35 ББСБ 22.5 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл, 109 ББСБ 111.4 тэрбум төгрөгийн бусад өмчийн үлдэгдэлтэй гарчээ.


Хүснэгт 33 Бусад өмч, сангуудын бүтэц (сая төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	22,523.9	13,943.4	1,322.2	21,201.8	-	22,397.2	126.7	-	6.5
Бусад өмч	111,389.6	106,120.3	12,908.1	98,481.5	-	09,973.2	1,416.4	15,889.1	6,871.1

Хуримтлагдсан ашиг

Хуримтлагдсан ашиг өмнөх оны мөн үеэс 51.3% буюу 681.6 тэрбум төгрөгөөр өсөж 2.0 их наяд төгрөгт хүрчээ.


Зураг 14 Хуримтлагдсан ашиг/алдагдал (тэрбум төгрөгөөр)



Тайлант хугацаанд 489 ББСБ нийт 461.6 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан бол 8 ББСБ үйл ажиллагаа эрхлээгүй, 76 ББСБ 3.9 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Алдагдалтай ажилласан 76 ББСБ дотор эх үүсвэр татан төвлөрүүлсэн 10 ББСБ байна. Эдгээрийн үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалтыг яаралтай хийж гүйцэтгэх шаардлагатай.


Зураг 15 Тайлант үеийн ашиг/алдагдал (тэрбум төгрөгөөр)



Ашигт ажиллагаа

2025 оны II улирлын байдлаар ББСБ-ууд 1,264.9 тэрбум төгрөгийн орлого олж, 807.2 тэрбум төгрөгийн зардал гаргаж, 457.7 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

Зураг 16 Ашигт ажиллагааны үзүүлэлт (тэрбум төгрөгөөр)



Өмнөх оны мөн үеэс орлогын хэмжээ 57.9% буюу 464.0 тэрбум төгрөгөөр, зардлын хэмжээ 69.6% буюу 331.4 тэрбум төгрөгөөр, ашгийн хэмжээ 40.8% буюу 132.6 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 34 Орлого, үр дүнгийн тайлан (харьцуулсан, сая төгрөгөөр)

Орлого, зардлын зүйл	2024-II	2025-II	Нийт дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
				Дүн	Хувь
НИЙТ ОРЛОГО	800,936.1	1,264,896.3	100.0%	463,960.3	57.9%
Хүүгийн орлого	712,857.3	1,129,248.5	89.3%	416,391.2	58.4%
Хүүгийн бус орлого	72,148.9	107,130.0	8.5%	34,981.0	48.5%
Бусад орлого, олз	15,929.9	28,327.9	2.2%	12,398.1	77.8%
Бусад дэлгэрэнгүй орлого	0.0	189.9	0.0%	189.9	0.0%
НИЙТ ЗАРДАЛ	475,799.3	807,183.5	100.0%	331,384.2	69.6%
Хүүгийн зардал	167,718.1	297,964.0	36.9%	130,245.9	77.7%
Хүүгийн бус зардал	201,341.8	265,095.3	32.8%	63,753.5	31.7%
Эрсдэлийн сангийн зардал	46,241.8	147,579.3	18.3%	101,337.5	219.1%
Бусад зардал, гарз	6,928.2	10,249.6	1.3%	3,321.4	47.9%
Орлогын албан татварын зардал	53,569.4	86,295.3	10.7%	32,725.9	61.1%
ЦЭВЭР АШИГ	325,136.8	457,712.9		132,576.1	40.8%

Нийт орлогын 89.3 хувийг хүүгийн орлого, нийт зардлын 36.9 хувийг хүүгийн зардал, 32.8 хувийг хүүгийн бус зардал бүрдүүлж байна. Хүүгийн бус зардлын 85.1 хувийг үйл ажиллагааны бусад зардал бүрдүүлж байгаа бөгөөд үүний 48.7 хувийг ажилтнуудын цалинтай холбоотой зардал бүрдүүлж байна.

Хүснэгт 35 Орлого, үр дүнгийн тайлан (тэр төгрөгөөр)

	Дүн	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
НИЙТ ОРЛОГО	1,264.9	983.0	389.5	875.4	2.9	1,247.7	17.2	216.4	134.2
Хүүгийн орлого	1,129.2	883.9	352.6	776.7	0.1	1,114.0	15.3	189.7	121.2
Хүүгийн бус орлого	107.1	76.7	25.2	81.9	2.7	105.5	1.7	14.8	4.2
Бусад орлого, олз	28.3	22.2	11.7	16.6	0.0	28.0	0.3	11.9	8.7
НИЙТ ЗАРДАЛ	807.2	652.4	221.0	586.2	1.4	798.5	8.7	168.7	105.3
Хүүгийн зардал	298.0	272.7	67.6	230.4	-	297.2	0.8	76.3	49.6
Хүүгийн бус зардал	265.1	187.4	88.9	176.2	1.3	259.9	5.2	33.0	19.6
Арилжааны зардал	2.1	1.7	0.7	1.3	0.0	2.1	0.0	0.1	0.0
Хани, үнэлгээний тэгшитгэлийн зардал	20.7	18.9	5.2	15.6	0.0	20.7	0.0	4.7	0.2
Хураамж, шимтгэлийн зардал	16.7	15.3	1.9	14.7	0.2	16.6	0.1	2.3	0.3
Үйл ажиллагааны бусад зардал	225.7	151.5	81.1	144.5	1.1	220.5	5.1	25.9	19.2
Эрсдэлийн сангийн зардал	147.6	113.2	38.7	108.9	-	145.7	1.9	45.9	28.7
Бусад зардал, гарз	10.2	7.1	3.5	6.8	0.0	10.1	0.2	1.2	0.8
ОАТ-ын зардал	86.3	72.0	22.4	63.9	0.0	85.7	0.6	12.3	6.6
НИЙТ ЦЭВЭР ОРЛОГО	457.7	330.6	168.6	289.1	1.5	449.2	8.6	47.7	28.9

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

2025 оны II улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн дүнгээр 573 ББСБ-ын 81.2% буюу 465 ББСБ үйл ажиллагааны ЗХШҮ-үүдийг бүрэн хангаж ажилласан байна.

Нийт ББСБ-уудын 18.8% нь буюу 108 ББСБ-ын зохистой харьцаа алдагдсан байна. Үүнд: 1 зохистой харьцааг хангаагүй 98 ББСБ, 2 зохистой харьцааг хангаагүй 8 ББСБ, 3 зохистой харьцааг хангаагүй 1 ББСБ, 5 зохистой харьцааг хангаагүй 1 ББСБ байна.

Хүснэгт 36 Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд (үзүүлэлт бүрээр)

№	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд	Итгэллэл /92 ББСБ/		Итгэллэл, ГВА-аас бусад /421 ББСБ/		ЗГВА /60 ББСБ/		Нийт /573 ББСБ/	
		√	X	√	X	√	X	√	X
1.	Нэгдүгээр эрэгдэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	92	-	421	-	60	-	573	-
2.	Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	92	-	421	-	60	-	573	-
3.	Өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	92	-	421	-	60	-	573	-
4.	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	89	3	412	9	60	-	561	12
5.	Хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (+илүү,- дутуу)	92	-	361	60	50	10	503	70
6.	Нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	91	1	416	5			569	6
7.	ББСБ-аас гаргасан төлбөрийн баталгааны зохистой харьцаа	92	-	421	-			575	-
8.	ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүнгийн зохистой харьцаа	92	-	421	-			571	-
9.	ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан, холбогдох нэг этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	92	-	415	6			570	6
10.	Үнэт цаасны эзэмшил өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	92	-	421	-	XXX		575	-
11.	Компанийн хувьцаа, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	92	-	419	2			574	2
12.	Монголын хөрөнгийн биржийн "I", "III" ангиллын нэг компанийн гаргасан хувьцаанаас худалдаж авах зохистой харьцаа	92	-	420	1			574	1
13.	Компанийн өрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	92	-	420	1			574	1
14.	Бусад үнэт цаас, үнэт цаасны эзэмшлийн зохистой харьцаа	92	-	421	-			574	-
15.	Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	92	-	418	3			557	3
16.	Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	91	1	XXX				575	-
17.	Итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн нөөц сан	86	6	420	1			575	7
18.	Өрийн бичгийн зохистой харьцаа	92	-	419	2			573	2
19.	Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	91	1	412	9	59	1	11	11

Тайлбар: √ - ЗХШҮ хангасан ББСБ-ын тоо, X - ЗХШҮ хангаагүй ББСБ-ын тоо


ББСБ-уудын хангах ёстой ЗХШҮ-үүдээс хөрөнгө (актив)-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ дутуу байгуулсан 24 ББСБ, илүү байгуулсан 46, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа алдагдсан 12 ББСБ, итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн нөөц сан байгуулаагүй 7 ББСБ, үндсэн хөрөнгийн зохистой харьцаа алдагдсан 11 ББСБ байгаа нь хамгийн их алдагдсан харьцаа үзүүлэлтүүд байна.

Итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа алдагдсан нэр бүхий 3 ББСБ-д холбогдох арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

Өгөөжийн үзүүлэлтүүд

2025 оны II улирлын байдлаар салбарын нийт хөрөнгийн өгөөж 6.7 хувь нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад өөрчлөгдөөгүй, харин өөрийн хөрөнгийн өгөөж 12.4 хувь байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.9 пунктээр өссөн байна.

Зураг 17 Салбарын өгөөжийн үзүүлэлт сүүлийн 5 жилээр



Гадаад валютын арилжааны мэдээ

Тайлант хугацаанд буюу 2025 оны II улиралд гадаад валютын арилжааны тусгай зөвшөөрөлтэй 178 ББСБ-аас ирүүлсэн тайлан мэдээгээр 3.4 их наяд төгрөгийн валют худалдан авсан нь банкны салбарын 21.4 хувьтай, 3.6 их наяд төгрөгийн валют зарсан нь банкны салбарын 24.8 хувьтай тэнцэж байна.

Хүснэгт 37 2025 оны II улирлын байдлаарх валют арилжааны мэдээ (сая төгрөгөөр)

	Нийт дүн		Авсан I улирал	Зарсан I улирал	Авсан II улирал	Зарсан II улирал
	Авсан	Зарсан				
Нийт дүн	3,420,047.8	3,590,790.1	1,577,986.6	1,766,645.8	1,842,061.2	1,824,144.3
АНУ доллар	1,769,369.1	1,990,974.5	817,969.5	1,062,963.6	951,399.5	928,010.9
Евро	139,492.0	137,809.5	51,851.1	52,367.4	87,640.9	85,442.0
Японы иен	43,738.6	40,732.8	24,875.2	23,367.8	18,863.4	17,365.0
Швейцар франк	9,769.4	9,684.4	4,776.2	4,723.3	4,993.3	4,961.2
Шведийн крон	32.7	27.9	10.9	7.7	21.7	20.3
Английн фунт	830.4	878.8	374.2	439.4	456.2	439.3
Энэтхэгийн рупи	8.8	9.0	-	-	8.8	9.0
Хонгконг доллар	4,050.8	4,430.7	2,094.2	2,297.1	1,956.7	2,133.6
ОХУ-ын рубль	446,562.1	380,710.6	233,550.5	170,542.3	213,011.6	210,168.3
Казахстан тэнгэ	28.8	19.6	1.7	-	27.1	19.6
БНХАУ-ын юань	935,447.3	947,601.5	413,604.1	418,526.2	521,843.2	529,075.3
БНСУ-ын вон	66,168.7	65,722.7	27,541.6	27,554.7	38,627.1	38,168.0
Канадын доллар	268.9	271.3	68.0	78.5	200.9	192.8
Австралийн доллар	2,586.9	2,502.4	707.6	680.7	1,879.4	1,821.7
Чех крон	11.8	5.7	-	-	11.8	5.7
Тайван доллар	1.1	-	-	-	1.1	-
Тайланд баг	116.2	136.2	103.2	124.5	13.1	11.7
Сингапур доллар	1,504.4	9,272.6	398.9	2,972.8	1,105.5	6,299.8
Малайзын ринггит	1.7	-	1.7	-	-	-
БНАСАУ-ын вон	58.1	-	58.1	-	-	-

Дүгнэлт

2025 оны II улирлын байдлаар тайлан мэдээг ирүүлбэл зохих 573 ББСБ-аас 573 ББСБ жилийн тайлан мэдээ ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 8 ББСБ өмнөх үеийн тайлан тэнцлээр, нэр бүхий 3 ББСБ эхлэлтийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа. 2025 оны II улирлын байдлаар давхардсан тоогоор 36,348 хувьцаа эзэмшигчдийн 573 ББСБ, 561 салбар нэгж, 11 төлөөлөгчийн газар, 6,412 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 8 дүүрэгт давхардсан тоогоор 3.6 сая харилцагч, 2.8 сая зээлдэгчид хүрч үйлчилж байна.

Актив, пассивын бүтэц

ББСБ-уудын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 38.7 хувиар өсөж, банкны салбарын 11.0%-тай тэнцэж байна. Харин хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ банкны салбарын 109.0%-тай тэнцэж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.3 пунктээр өссөн дүн юм.

2025 оны II улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагын салбарын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 38.7 хувиар буюу 2.2 их наяд төгрөгөөр өсөж 8.0 их наяд төгрөгт хүрсэн байна. Активын өсөлтийн 93.6 хувийг зээлийн өсөлт, пассивын өсөлтийн 47.2 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

ББСБ-ууд нь ихэвчлэн өөрийн хөрөнгөд тулгуурлан үйл ажиллагаа эрхэлдэг онцлогтой байсан хэдий ч сүүлийн жилүүдэд бусдаас итгэлцэл, өрийн бичиг, дотоод, гадаадын банк санхүүгийн байгууллага, төсөл хөтөлбөр хэлбэрээр мөн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах замаар эх үүсвэр татах нь нэмэгдэж байгаа тул тэдгээр /158 ББСБ/ ББСБ-уудын тайлан мэдээнд онцгой анхаарал хандуулах шаардлагатай байна.

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 45.4 хувь буюу 2.1 их наяд төгрөгөөр өсөж 2025 оны II улирлын байдлаар 6.7 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд үүнд 357.5 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 6.6 их наяд төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

Зээлийн багцын 87.3 хувийг буюу 5.8 их наяд төгрөгийг хэвийн зээл, 5.0 хувийг буюу 332.4 тэрбум төгрөгийг анхаарал хандуулах зээл, 7.7 хувийг буюу 514.0 тэрбум төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 3.5 пунктээр буурсан бол, чанаргүй зээлийн хэмжээ 1.5 пунктээр анхаарал хандуулах зээл 2.0 пунктээр тус тус өссөн байна. Анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн 846.3 тэрбум төгрөгийн үлдэгдлийн 42.2 хувьд буюу 357.5 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан байна.

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгон, уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй 72 ББСБ 66 финтек зээлийн аппликэйшнээр дамжуулж цахим зээлийн үйлчилгээ үзүүлж байна. 2025 оны II улирлын байдлаар эдгээр ББСБ-ууд зөвхөн аппликэйшний 2.3 сая зээлдэгчийн 1.8 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа нь нийт зээлдэгчийн 88.5 хувь, нийт зээлийн үлдэгдлийн 28.0 хувийг бүрдүүлж байна. Зөвхөн аппликэйшнээр нэг зээлдэгчид дунджаар 756.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь уламжлалт зээлийн дунджаас 19.8 дахин бага байна. Цахим зээлийн мэдээлэл ирүүлээгүй 18 ББСБ-уудад холбогдох арга хэмжээг авах шаардлагатай байна.

Салбарын нийт пассив өмнөх оны мөн үеэс 38.7 хувиар буюу 2.2 их наяд төгрөгөөр өссөн ба энэхүү өсөлтийн 52.8 хувийг өр төлбөрийн өсөлт, 47.2 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад өр төлбөрөөс итгэлцлийн үйлчилгээний өглөг 1.3 дахин, банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр 1.6 дахин, бусад эх үүсвэр 1.4 дахин, үүсмэл санхүүгийн өр төлбөр 8.4 дахин, бусад санхүүгийн өр төлбөр 1.5 дахин,

барагдуулах ёстой хоёрдогч өглөгийн өр төлбөр 11.1 дахин өссөн бол өөрийн хөрөнгөөс хуримтлагдсан ашиг 51.3 хувиар, хувь нийлүүлсэн хөрөнгө 17.7 хувиар, нэмж төлөгдсөн капитал 25.3 хувиар тус тус өссөн байна.

Ашигт ажиллагаа

2025 оны II улирлын байдлаар ББСБ-ууд 1,264.9 тэрбум төгрөгийн орлого олж, 807.2 тэрбум төгрөгийн зардал гаргаж, 457.7 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

Өмнөх оны мөн үеэс орлогын хэмжээ 57.9% буюу 464.0 тэрбум төгрөгөөр, зардлын хэмжээ 69.6% буюу 331.4 тэрбум төгрөгөөр, ашгийн хэмжээ 40.8% буюу 132.6 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

2025 оны II улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн дүнгээр 573 ББСБ-ын 81.2% буюу 465 ББСБ үйл ажиллагааны ЗХШҮ-үүдийг бүрэн хангаж ажилласан байна.

Нийт ББСБ-уудын 18.8% нь буюу 108 ББСБ-ын зохистой харьцаа алдагдсан байна. Үүнд: 1 зохистой харьцааг хангаагүй 98 ББСБ, 2 зохистой харьцааг хангаагүй 8 ББСБ, 3 зохистой харьцааг хангаагүй 1 ББСБ, 5 зохистой харьцааг хангаагүй 1 ББСБ байна.

ББСБ-уудын хангах ёстой ЗХШҮ-үүдээс хөрөнгө (актив)-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ дутуу байгуулсан 24 ББСБ, илүү байгуулсан 46, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа алдагдсан 12 ББСБ, итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн нөөц сан алдагдсан 7 ББСБ, үндсэн хөрөнгийн зохистой харьцаа алдагдсан 11 ББСБ байгаа нь хамгийн их алдагдсан харьцаа үзүүлэлтүүд байна.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР